

Өөрийгөө танихуй

*дехи нитйам авадохйо' йам
дехе сарвасйа бхарата
тасмат сарвани бхутани
на твам шочитум архаси*

“Ай Бхаратын удам минь ээ, биед хувилан төрөгч нь мөнх хийгээд түүнийг алж устгах боломжгүй бөлгөө. Иймийн тул хэн нэгний хойноос бүү энэлэн гашууд” (Бхагавад-гита, 2.30).

Өөрийгөө танин ухамсарлахуйн зам дээр гарсан хүний хувьд хамгийн нэгдүгээрт өөрийнхөө бие махбодиос өөрийгөө ялган таних нь чухал. Үхлийн савраас мултарч сүнсний ертөнц рүү одохыг хүсэгч хүн бүр нь: “Би энэ бие биш, би бурханлаг сүнс” гэдгээ ойлгож мэдэрсэн байх нь нэн чухал. Гэвч зүгээр л: “Би энэ бие биш” гэж хэлэх нь хангалтгүй. Энэ нь өнгөц харахад л үзэгдчихэж болох тийм хялбар зүйл биш гэдгийг жинхэнэ ёсоор ухамсарлах хэрэгтэй. Бид хэдий бие махбодь биш ч бид буюу цэвэр тунгалаг ухамсар маань бие махбодийн торонд орсон юм. Хэрэв бид үнэхээр үхэлгүй мөнхийн аз жаргал, эрх чөлөөг хүсэж буй бол өөрийн анхдагч байр сууриндаа эргэн очих ёстой. Өөрөөр хэлбэл цэвэр ухамсраа эргүүлэн олж авч, үргэлж тэр ухамсартаа оршин байх.

Бид өөрсдийгөө бие махбодитойгоо адилтгадаг учраас аз жаргалын тухай бидний төсөөлөл нь дэмийрч солиорсон хүний төсөөлөлтэй адил. Зарим нэг гүн ухаантнууд өөрийгөө биетэйгээ адилтгах солиорлын төлөв байдлаас ангижирахын тулд бүхий л үйлээс татгалзах ёстой гэж батладаг. Тэд хэлэхдээ, бид бүхий л материалаг үйлээ таслан зогсоох ёстой бөгөөд учир нь тэр нь зовлонгийн эх булаг юм гэж батладаг. Төгс төгөлдрийн дээдийг тэд, амьд бодгаль нь бүхий л үйлээ таслан зогсоосон буддын нирваныг санагдуулам тийм төлөв байдал юм гэж тооцдог. Будда, бие махбодь нь материаллаг элементүүдийн нэгдлийн дүнд бий болсон бөгөөд ямар нэг байдлаар тэднийг нэг нэгээс нь салгавал зовлонгийн шалтгаан нь алга болно хэмээн айлдсан байдаг. Хэрэв татвар хураагч бидний эзэмшдэг том байшингаас болж биднийг хэтэрхий их залхаавал тэр байшингаа нурааж болноо доо. Энэ бол нөхцөл байдлаас зайлж болох гарц. Гэвч “Бхагавад-гита”, материаллаг бие махбодь нь хамгийн гол чухал зүйл биш хэмээн баталж байна. Энэхүү материаллаг элементүүдийн нэгдлийн цаана сүнс оршдог. Түүний оршин буйг ухамсар оршин буйгаар л илрүүлчихэж болно.

Ухамсар оршин буйг үгүйсгэх аргагүй бөгөөд ухамсар үгүй бие нь үхмэл юм. Үүнийг жаахан хүүхэд ч ойлгож чадахсан. Биеийг амьд байлгахад ухамсар зайлшгүй чухал гэдэг нь маргашгүй баримт. Тэгвэл ухамсар гэж юу юм бэ ? Утаа болон дулаан нь гал оршин буйг илэрхийлдэг шиг, ухамсар нь сүнс оршин буйг гэрчилдэг. Сүнсний эрчим хүч буюу амьд бодгалийн “би” нь ухамсар хэлбэрээр илэрдэг. Үнэн хэрэгтээ, илэрч буй ухамсраар нь сүнс оршин буйн тухай дүгнэлт хийж болно. Энэ тухай “Бхагавад-гита” төдийгүй бүхий л ведийн бичээсүүд сургадаг.

Шанкарачарйагийн залгамжлагчид, имперсоналистууд болон Бурхан Кришнагаас эхлэлтэй багш шавийн барилдлагад хамаарах вайшнавууд нь сүнс оршин буйг хүлээн зөвшөөрдөг байхад харин буддын гүн ухаантнууд түүнийг үгүйсгэдэг. Буддистууд материаллаг элементүүдийн нэгдлийн дүнд тодорхой үе шатанд ухамсар бий болдог гэж батладаг. Гэвч бүх зүйл материаллаг элементүүдийн захиргаанд оршдог ч бид ухамсрыг бий болгож чадахгүй. Энэ нь дээрх баталгааны учир дутагдалтайг нотолж байна. Үхсэн

хүний биед бүхий л материаллаг элементүүд агуулагддаг ч бид түүнд ухамсрыг нь буцаан авч ирж чадахгүй. Бидний бие махбодь машин техникээс ялгаатай. Машинаас ямар нэг эд анги нь унаж “жагсаалаас гарахад” түүнийг өөр нэгээр орлуулж болдог. Машин дахиад л ажиллаж эхэлнэ. Гэвч бие махбодь “жагсаалаас гарахад” буюу ухамсар биеийг орхиход эвдэрсэн эд ангийг солих буюу ухамсрыг буцаан авч ирж болдоггүй. Сүнс нь биеэс ялгаатай бөгөөд бие нь түүнд сүнс оршин буй цагт л амь ордог. Гэвч хэрэв биед сүнс үгүй бол түүнийг амьдруулах боломжгүй.

Бид, түүнийг өөрийн бүдүүлэг мэдрэхүйнүүдийн туслалцаатайгаар мэдрэх болон харж чадахгүй хэмээх үндэслэлээр сүнс оршин буйг батладаг. Үнэн хэрэгтээ бидний харж үл чадах зүйл асар олон. Бид (агаар, радио долгион буюу авиаг харж чаддаггүй) өөрсдийн хязгаарлагдмал мэдрэхүйн улмаас өчүүхэн жижиг бактерийг ч олж харж чаддаггүй ч эдгээр нь ерөөсөө оршин байдаггүй гэсэн үг огтхон ч биш. Микроскоп болон өөр ямар нэг төхөөрөмжийн тусламжтайгаар урьд нь төгс бус мэдрэхүйнүүдээр олж харж, мэдэрч чадаагүй тэдгээр олон зүйлсийг олж харж болно. Ийм учраас мэдрэхүйн эрхтэнүүдийн туслалцаатайгаар ч, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар ч атомын хэмжээтэй тэрхүү зүйлийг /сүнснийг/ олж харж чадахгүй тул сүнс нь үл оршин буй хэмээх дүгнэлт гаргах эрхгүй юм. Үнэндээ бол түүний оршин буйг гадаад шинж байдлаар ч илрүүлж болно.

“Бхагавад-гита”-д Шри Кришна, бидний бүхий л зовлонгийн үндэс нь бид өөрсдийгөө бие махбодитойгоо адилтгадагаас болдог тухай тайлбарласан байдаг.

*матра-спаршас ту каунтейа
шитошна-суккха-духкха-дах
агамапайно`нитийас
таис титикшасва бхарата*

“Ай Кунтийн хүү минь ээ, халуун хүйтний байнгын халаа сэлгээ, аз жаргал болоод зовлонгийн ирэх, буцах нь өвөл, зун ирэх буцахтай адил бөлгөө. Энэ бүгдийн эх үндэс нь мэдрэхүйн хүртэц бүлгээ. Ай Бхаратын удам минь ээ, сэтгэлийн тэнцвэрт байдлаа үл алдан, энэхүү халаа сэлгээнүүдийг тэвчээртэйгээр даван туулахад суралцах хэрэгтэй амой” (Бхагавад-гита. –2.14). Зуны улиралд усанд хүрвэл энэ нь бидэнд таашаал ханамж авчирдаг. Харин өвөл бид түүнээс аль болох хол байхыг эрмэлздэг. Учир нь тэр тухайн улиралд хэтэрхий хүйтэн болдог. Аль, аль тохиолдлын хувьд ус, ус хэвээрээ байдаг ч бие махбодь түүнтэй хүрэлцсэнээр нэг бол ханамж, нэг бол зовлон авчирдаг.

Аз жаргал ба зовлонг мэдрэх бүхий л мэдрэмж нь бие махбодитой холбоотой. Нэг тохиолдолд бие болоод ухаан нь аз жаргалыг мэдэрдэг, нөгөө тохиолдолд зовлон зүдгүүрийг мэдэрдэг. Үнэн хэрэгтээ бол бид аз жаргалд л тэмүүлж буй. Учир нь аз жаргал гэдэг нь сүнсний байх л ёстой тэр төлөв юм. Сүнс гэдэг нь Өөрийн мөн чанар нь *сач-чид-ананда-виграха* буюу эрдэм мэдлэг, аз жаргал, үхэлгүй мөнхийн биелэл болсон Дээд Бодгалийн салшгүй хэсэг. “Кришна” хэмээх нэр нь өөрөө утгын хувьд хэрхэвч ямар нэг шашны урсгал чиглэлийг илэрхийлдэггүй бөгөөд “аугаа их цэнгэл” гэсэн утгатай. Криш гэдэг нь “аугаа их”, на нь “цэнгэл” гэсэн үг юм. Кришна нь цэнгэл, жаргалын биелэл хийгээд Түүний салшгүй хэсэг болсон бид мөн л цэнгэл жаргалыг тун ч их хүсдэг. Далайн дусал ус яг л далайн өөрийн найрлагатай адил байдаг шиг, хэдий бид Дээд Бүхэл Бүтний тун ч өчүүхэн жижиг хэсгүүд гэлээ ч бид Бүхний Дээдийн эрчим хүчний шинж чанартай адил чанарыг өөртөө шингээсэн байдаг.

Атомлаг сүнс нь хэдий өчүүхэн жижиг хэмжээтэй ч олон, олон янзын үйлийг хийх боломж олгон бие махбодийг хөдөлгөөнд оруулдаг. Энэ дэлхий дээр тоогүй олон хотууд баригдаж, зам гүүр тавигдаж, аварга том цогцолборууд, хөшөө баримлууд сүндэрлэж, аугаа их соёл бүтээн байгуулалт бий болсоор байна. Гэтэл хэн эднийг бүтээчихээ вэ? Энэ

бүгдийг биеийн дотор оршигч тэр өчүүхэн жижиг сүнсний оч бүтээн бий болгосон юм. Хэрэв өчүүхэн жижиг сүнсний оч тийм гайхалтай зүйлүүдийг бүтээж чадаж байгаа юм бол Дээд Бурханлаг Бүхэл Бүтэн нь ямархан зүйлийг хийж чадахыг төсөөлөхөд ч бэрх. Бүхэл Бүтэнд байх эрдэм мэдлэг, аз жаргал, үхэлгүй мөнхийн чанарыг олж эзэмшихийг хүсэх нь өчүүхэн жижиг сүнсний хувьд жам ёсны зүйл ч энэ хүслээ биелүүлэхэд нь материаллаг бие махбодь саад болмуй. Сүнсний хүслийг хэрхэн биелүүлэх тухай “Бхагавад-гита”-д айлдсан буй.

Орчин үед бид үхэлгүй мөнх хийгээд эрдэм мэдлэг, аз жаргалыг төгс бус багаж зэвсгийн тусламжтайгаар олж авахыг санаархаж байна. Энэ зорилгод ойртоход бидэнд материаллаг бие юу ч өгдөггүй учраас бидний ахуй бие махбодиас хамаарахгүй юм гэдгийг ойлгон ухамсарлах ёстой. Бид бие махбодиосоо ялгаатай хэмээх ганц онолын мэдлэг ер хангалтгүй. Бид өөрсдийгөө үргэлж бие махбодиос хамааралгүй хийгээд түүний зарц боол биш харин эзэн нь байх ёстой гэдгээ мэдэрч байх хэрэгтэй. Хэрэв бид машин жолоодохыг сайн мэддэг бол энэ нь бидэнд машинаар явахад сайхан дэм болох хийгээд хэрэв мэдэхгүй бол бидэнд аюултай байх нь тодорхой.

Бие нь мэдрэхүйн эрхтэнүүдээс тогтдог бөгөөд мэдрэхүйнүүд нь үргэлж мэдрэхүйн объектуудаар цэнгэхийг хүсэж байдаг. Нүд ямар нэг сайхан хүн хараад бидэнд: “Өө, тэнд нэг үзэсгэлэнтэй бүсгүй, сайхан залуу явж байна. Явъя, харъя” гэнэ. Харин чих бидэнд: “Пөөх, ямар гайхалтай хөгжим бэ? Явъя, сонсьё” гэнэ. Хэл: “Пөөх, би нэг хачин амттай хоол хийдэг гайхалтай гоё ресторан мэднэ. Хамтдаа тийшээ явъя” гэнэ шүү дээ. Ингэж мэдрэхүйнүүд биднийг самууруулж, тал талаас тарчилгана.

*индрийанам хи чаратам
йан мано `нувидхийате
тад асйа харати праджнам
вайур навам ивамбхаси*

“Хүчит салхи завийг авч явдаг шиг, ганц, цорын ганц мэдрэхүй нь хүмүүнийг эзэмдэж, түүнээс оюун ухааныг нь булаан авмуй”(Бхагавад-гита, -2.67).

Хүн бүр өөрийн мэдрэхүйнүүдээ удирдаж сурах ёстой. Хэн бээр өөрийн мэдрэхүйнүүдээ эзэмдэж сурнав, түүнд *госвами* хэмээх цол хайрладаг. *Го* нь “мэдрэхүй”, харин “*свами*” нь “эзэн” гэсэн утгатай. Тэгэхээр өөрийн мэдрэхүйнүүдээ эзэмдэж сурсан хүмүүнийг *госвами* гэж тооцох ёстой. Кришна, хүн өөрийгөө өөрийн хуурмаг бие махбодитойгоо адилтгаж байсан цагт тэрээр өөрийгөө бурханлаг сүнс гэдгээ ухамсарлаж, өөрийн жинхэнэ “би”-гээ олж авч чадахгүй хэмээн тайлбарлажээ. Биеийн цэнгэл таашал нь цаг зуурын бөгөөд хүмүүнийг согтоон мансууруулдаг. Үнэндээ бол бид жинхэнэ ёсоор цэнгэж чаддагүй бөгөөд цэнгэл жаргал гээч тун хурдан өнгөрч оддог. Жинхэнэ цэнгэл жаргал гэдэг нь бие махбодийнх биш, сүнсний цэнгэл жаргал юм. Ийм учраас мэдрэхүйн цэнгэл жаргал бидний анхаарлыг сарниахгүй байхаар өөрийн амьдралаа зохиох хэрэгтэй. Хэрэв ямар нэг зүйл бидний анхаарлыг сарниулвал, биеийн хувьд трансцендент өөрийн жинхэнэ ”би”-дээ анхаарлаа төвлөрүүлж чадахгүй.

*бхогашивариа – прасактанам
тайанахрита - четасам
вайавасайатмика буддхих
самадхау на видхийате
траигунья – вишайа веда
нистраигунйо бхаварджуна
нирдвандво нитйа – саттва – стхо*

“Мэдрэхүйн цэнгэл болоод материаллаг эд баялагт хэтэрхий ихээр уягдаж, үүндээ будилж самуурагчийн ухаанд Дээд Бурханд чин бишрэлээр хүчин зүтгэхэд өөрийгөө бүрнээ зориулах шийдвэр хэзээ ч төрөхгүй юмаа. Ведүүдэд материаллаг байгалийн гурван гунын талаар өгүүлсэн байдаг. Ай Арджуна минь ээ, эдгээр гунуудын нөлөөллөөс ангижирч, түүний хувьд трансцендент бологтун. Амар хялбар олз ашиг, аюулгүй байдалд тэмүүлэхтэй холбогдсон бүхий л түгшүүр хоёрдмол байдлаас салж, өөрийн жинхэнэ “би”-дээ баттай орш” (Бхагавад-гита, -2.44-45).

“Веда” хэмээх үг нь “мэдлэгийн ном” гэж орчуулагддаг. Янз бүрийн улс оронд, янз бүрийн нийгэм, ард түмэнд олон янзын мэдлэгийг агуулсан олон олон ном байдаг. Энэтхэгт мэдлэгийн номыг Ведүүд гэж тооцдог. Баруунд энэ нь Хуучин болоод Шинэ гэрээ юм. Мусульман шашинтнууд үүнийг Коран гэж хүлээн зөвшөөрдөг. Энэ бүх номууд дахь мэдлэгийн зорилго юу юм бэ? Тэдгээр нь, бидэнд өөрсдийгөө цэвэр сүнс юм гэдгийг ойлгож ухамсарлахад маань туслахын тулд оршдог. Тэдний зорилго нь хэвт ёсны хууль гэж нэрлэгдэх тодорхой хууль болоод хоригуудын хүрээнд материаллаг үйлийг хязгаарлахад оршдог. Жишээ нь Библид, бидний амьдралыг түвшин болгох арван номлол бий. Дээд төгс төгөлдөрт хүрэхэд өөрийн бие махбодио удирдан залуурдаж сурах нь зайлшгүй чухал. Зохицуулах зарчмуудыг дагаж мөрдөхгүй бол бид амьдралын төгс төгөлдөрт хүрч чадахгүй. Зохицуулах зарчмууд нь янз бүрийн улс оронд эсвэл ариун судар бичгүүдэд ялгаатай байж болох ч энэ нь тийм ч чухал биш. Учир нь тэдгээр нь тухайн тухайн хүмүүсийн ухааны цараа, нөхцөл байдал, цаг хугацааны онцлогтой уялдсан байдаг. Гэвч амьдралыг хэв журамтай болгох зарчим нь өөрөө өөрчлөгдөлгүй хэвээр үлддэг. Үүнийг тухайн улс орны бүх ард иргэд дагаж мөрддөг засаг төрийн тогтоосон хуультай адилтгаж болно. Хууль үгүй бол улс орныг удирдах хийгээд нийгэм, соёлыг хөгжүүлэх ямар ч боломжгүй юм. Дээр иш татсан шүлгэнд Шри Кришна, Арджунад, Ведүүдэд агуулагддаг зохицуулах зарчмууд нь материаллаг байгалийн гурван гуна /буяны, шунал тачаалын, мунхаг харанхуйн (*траигунья-вишайа ведах*)/ - г удирдахад зориулагдсан байдаг хэмээн айлдаж байна. Гэвч Кришна, Арджунад материаллаг ертөнцийн хоёрдмол байдлын хувьд трансцендент, бурханлаг сүнсний төлөвтөө буцан очихыг зөвлөж байна.

Бидний дээр өгүүлсэнчлэн, эдгээр хоёрдмол байдлын илрэл: халуун болоод хүйтэн, өвдөлт болоод сэтгэл хамамжийг мэдрэх нь, мэдрэхүйнүүд түүний объектуудтай хүрэлцсэний улмаас бий болдог. Өөрөөр хэлбэл тэдгээрийн үүсэх болсон шалтгаан нь бид өөрсдийгөө бие махбодитойгоо адилтгадгаас улбаатай. Кришна, өргөл тахилга хийдэг, хэв журамт амьдралыг мөрддөг хүмүүнд диваажингийн цэнгэл амлах Ведийн үг нь цэнгэл жаргал болоод эрх мэдэлд дуртай хүмүүсийг өөртөө татдаг хэмээн батлан айлджээ. Цэнгэн жаргах эрх нь бидний хасашгүй эрх. Учир нь энэ нь бурханлаг сүнсний мөн чанар юм. Гэвч бурханлаг сүнсний алдаа нь, тэрбээр материаллаг объектуудаар цэнгэн жаргахыг санаархаж байдагт оршино.

Энд бүгд л материаллаг зүйлээс аз жаргалыг эрэлхийлж, өөрийн боломжийн хирээр мэдлэг хуримтлуулж байна. Зарим нэг нь химич физикч, зарим нь улстөрч, зураач, ямар нэг мэргэжилтэй болдог. Хүн бүр л бүх зүйлийн талаар бага зэрэг эсвэл ямар нэг зүйлийн талаар бүхнийг мэддэг. Үүнийг ерөнхийд нь мэдлэг гэж нэрлэдэг. Гэвч бид энэ биеийг орхих цагт үүнтэй хамт энэ бүх мэдлэг төгсгөл болно. Урьд амьдралдаа /урьд төрөлдөө/ хүн асар их мэдлэг хуримтлуулсан байж болох ч энэ амьдралдаа тэрээр бүгдийг дахин шинээр эхлэх хэрэгтэй болж, уншиж, бичиж сурахаар дахин сургуульд явдаг. Бид урьд төрөлдөө мэддэг байсан бүхнээ бүгдийг мартана. Үнэн хэрэгтээ бол бид цаг зуурын бус мэдлэгийг эрж хайж байгаа ч түүнийг материаллаг бие махбодийн тусламжтайгаар олж авах боломжгүй юм. Бид бүгдээрээ өөрийн бие махбодиороо цэнгэл жаргал эдлэхийг

хүсдэг ч бие махбодийн цэнгэлийг жинхэнэ цэнгэл гэж нэрлэх аргагүй. Тэр цэнгэл нь жам ёсноос гажууд юм. Бидэнд энэхүү жам ёсноос гажууд цэнгэл жаргалыг амтлах хүсэл байсан цагт бид цаг зуурын аз жаргалыг олж авч өөрийн анхдагч /уугуул/ төлөвт буцаж чадахгүй гэдгийг ойлгох ёстой.

Биед оршин буй амьд бодгалийн төлөв байдлыг өвчилсөн төлөв байдал гэж тооцох хэрэгтэй. Өвчтэй хүн жинхэнэ ёсоор цэнгэж чадахгүй. Жишээ нь, шарласан хүнд мөсөн чихэр гашуун мэт санагддаг ч эрүүл хүн түүний амттай сайхныг мэдэрч чадна. Аль ч тохиолдолд мөсөн чихэр мөсөн чихрээрээ байвч бид өөр, өөрсдийн төлөв байдлаасаа хамаарч түүний амтыг янз бүрээр мэдэрч байна. Энэ өвчнөө эмчлүүлээгүй цагт (өөрийгээ бие махбодитойгоо адилтгах) бид сүнсний амьдралын амтыг мэдэрч чадахгүй. Тэр бүү хэл сүнсний амьдрал бидэнд гашуун мэт санагдах болно. Хэн материаллаг ханамж, таашаалд улам, улам автнав, тэрээр зөвхөн өөрийн өвчнөө улам, улам архагшуулж буй юм. Гэдэсний хижгээр өвдсөн хүнд хатуу хоол хүнс хориотой. Хэрэв хэн нэг нь түүнийг баярлуулах гэж тийм хоол хүнс өгвөл тэр хүн хэрэв түүнийг нь идвэл энэ нь амь насыг нь аюулд учруулах юм уу түүний байдлыг улам дортгоно. Хэн үнэхээр зовлон зүдгүүрээс ангижирахыг хүснэ, тэр бие махбодийн цэнгэл болоод өөрийн биеийн хэрэгцээ шаардлагыг хамгийн бага түвшинд аваачих ёстой.

Үнэн хэрэгтээ материаллаг цэнгэл жаргалыг цэнгэл жаргал гэж ердөөсөө ч тооцох аргагүй юм. Жинхэнэ цэнгэл жаргал нь хэзээ ч тасардаггүй. “Махабхарата”-д, йогчид(*йогино*) өөрөөр хэлбэл сүнсний түвшинд хүрэхийг тэмүүлж буй хүмүүн нь жинхэнэ цэнгэлийг (*раманте*) амсдаг бөгөөд тэр цэнгэл нь цаг зуурын бус (*ананте*) байдаг тухай өгүүлсэн нэгэн шүлэг (*раманте йогино нанте*) байдаг. Энэ нь тэдний цэнгэл жаргалын эх булаг нь дээд цэнгэл эдлэгч (Рама), Шри Кришна гэдгийг тайлбарлан өгч байна. Жинхэнэ цэнгэл эдлэгч нь Бхагаван Шри Кришна хийгээд энэ тухай “Бхагавад-гита”-(5.29)-д батлан айлдсан байдаг:

“Эцсийн дүндээ зөвхөн Би л бүхий л өргөл, тахилга хийгээд бүхий л тэвчлийн үрээр цэнгэдэг, Би бол бүхий л гариг эрхэс болоод сахиулсан тэнгэрүүдийн Дээд Бурхан, бүхий л амьд бодгальд сайн сайхныг хүсэгч, ивээгч гэдгийг ухамсарласан мэргэд нь материаллаг ахуйн мөн чанар болсон бүхий л зовлонгоос ангижирмуй”.

Бхога нь “цэнгэл жаргал” гэсэн үг бөгөөд өөрийнхөө байр суурийн хувьд бид цэнгэлийг эдлүүлэгч юм гэдгээ ойлгосон цагт жинхэнэ аз жаргалыг амсаж чадна. Жинхэнэ цэнгэл эдлэгч нь Дээд Бурхан бөгөөд бид бол Түүнд цэнгэл жаргалыг амсуулагчид нь юм.

Материаллаг ертөнц дээрх тийм харьцааны жишээ бол эрэгтэй, эмэгтэй хоёрын хоорондох харьцаа юм. Эрэгтэйг цэнгэл эдлэгч/*пуруша*/ гэж тооцдог хийгээд эмэгтэйг цэнгүүлэгч/*пракрити*/ гэж үздэг. При хэмээх үг нь “эмэгтэй хүн” гэсэн утгатай. *Пуруша*, өөрөөр хэлбэл сүнс – энэ нь субъект, харин *пракрити* буюу байгаль нь объект болно. Гэвч эр нь ч эм нь ч аль аль нь цэнгэлийг эдлэдэг. Тэд үнэхээр цэнгэлийг эдлэж байвал эрэгтэй нь эмэгтэйгээсээ илүү таашаал ханамж авч байна гэж хэлэх аргагүй. Эрэгтэй нь ноёлох байр суурь, эмэгтэй нь захирагдах байр суурь эзэлдэг ч тэд цэнгэл эдлэж байх үед энэ хязгаарлалт арилдаг. Хичнээн өсгөн тооцоод ч амьд бодгаль нь цэнгэл эдлэгч биш юм.

Бурхан Өөрийгөө олон, олноор тархааж чадах бөгөөд бид Түүний хэсэг. Өөрийн туршлагаас ганцаараа суугаад өөрөө өөртэйгээ ярих нь багахан таашаал ханамж авчирдагийг бид мэднэ. Харин таван хүн цуглараад суувал бид яриа хөөрөөнөөс таашаал цэнгэл авна. Тэгвэл асар олон сонсогчдын өмнө Кришнагийн тухай ярих боломж олдвол энэ цэнгэлийг юутай ч зүйрлэх аргагүй. Цэнгэл гэдэг нь олон янз хэлбэрийг илэрхийлдэг. Бурхан цэнгэл эдлэхийн тулд олон болдог хийгээд гарцаа байхгүй бидний анхдагч үүрэг бол Түүнд цэнгэл таашаал өгөх юм. Энэ бол бидний анхдагч байр суурь билээ. Энэ л зорилгоор бид бүтээгдсэн юм. Цэнгэл эдлэгч, цэнгүүлэгч хоёр хоёулаа ухамсартай ч, цэнгүүлэгчийн ухамсар нь цэнгэл эдлэгчийн ухамсарт захирагдаж байдаг. Хэдий Кришна

– цэнгэл эдлэгч, бид – цэнгүүлэгч гэлээ ч хүн бүр цэнгэлийг амтлах чадвартай. Гэвч жинхэнэ цэнгэлийг бид Бурханы цэнгэлд оролцох үед л амсаж чадна. Бид, физик түвшинд, Түүнээс хамааралгүйгээр цэнгэн жаргаж чадахгүй юм. “Бхагавад-гита”-д материаллаг бие махбодийн цэнгэл таашаалаас холхон байхыг олонтоо зөвлөсөн байдаг.

*матха спаршиас ту каунтейа
шитошна – сухкха-духкха-дах
агамайпайино `нитйас
тамс титикшасва бхарата*

“Ай Кунтийн хүү минь ээ, халуун хүйтний байнгын халаа сэлгээ, аз жаргал болоод зовлонгийн ирэх, буцах нь, өвөл, зун ирэх, буцахтай адил бөлгөө. Энэ бүгдийн эх үндэс нь мэдрэхүйн хүртэц бүлгээ. Ай Бхаратын удам минь ээ, сэтгэлийн тэнцвэрт байдлаа үл алдаж, энэхүү халаа сэлгээнүүдийг тэвчээртэйгээр даван туулахад суралцах хэрэгтэй амой” (Бхагавад гита, -2.14).

Бүдүүлэг физик бие махбодь нь материаллаг байглаийн гурван гунын харилцан үйлчлэлийн дүнд бий болдог бөгөөд устан мөхөх тавилантай билээ.

*антаванта име деха
нитйасйотах шаририних
анашишино `прамейасйа
тасмад йудхийасва бхарата*

“Устгагдашгүй, өөрчлөгдөшгүй, мөнхийн амьд бодгалийн зөвхөн бие махбодь нь л устаж мөхмүй. Ийм учраас ай Бхаратын удам минь ээ, тулалдагтун” (Бхагавад-гита, -2.18).

Иймээс Шри Кришна бидэнд, ахуйн тухай бие махбодийн төсөөллөөс дээш өгсөж, жинхэнэ сүнсний амьдралаар амьдарч эхлэхийг зөвлөж байна.

*гунан этани атитйа трин
дехи деха-самудбхаван
джанма-мртйу-джара-духкхаир
вимукто `мртам ашнута*

“Хэрэв биед хувиалан төрөгч нь эдгээр гурван гуныг /буяны, шунал тачаалын, мунхаг харанхуйн/ даван туулж чадвал тэрээр үхэх, төрөх, өглөх болоод түүнтэй холбоотой бүхий л зовлонгоос ангижирч, бүр энэ насандаа ч үхэлгүй мөнхийн рашааныг хүртмүй” (Бхагавад гита, -14.20).

Гурван гунын нөлөөллөөс дээш өгсөж, цэвэр сүнсний *брахма-бхутын* түвшин хүртэл өгсөн дээшлэхийн тулд бид Кришнагийн ухамсрын аргачлалд хандах ёстой. Үүнд хүрэхэд Чайтанья Махапрабхугийн бидэнд бэлэглэсэн Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама, Харе Харе хэмээсэн Кришнагийн алдар нэрийг давтан дуудах нь тус болмуй. Энэхүү аргачлалыг *бхакти-йог* буюу *мантра-йог* гэж нэрлэдэг хийгээд энэ аргачлалд трансцендент бясалгагчдын аль шилдгүүд нь ханддаг юм. Трансцендент бясалгагчид нь хэрхэн материаллаг бие махбодиос ангид үхэх, төрөхийн нөгөө талд оршигч өөрийгөө ухамсарладаг хийгээд хэрхэн яаж материйн ертөнцөөс сүнсний ертөнц рүү шилжин оддог тухай дараагийн бүлэгт өгүүлсүү.

2.

Үхэх агшинд өгсөн дээшлэх нь

Йогчид гэж нэрлэгдэх(хатха –йогчид, джана-йогчид, бхакти-йогчид) трансцендент бясалгагчдын олон ай бүлэг бий бөгөөд тэд бгдэд бурханлаг сүнсний ертөнцийн үүд хаалга нээлттэй. Йог хэмээх үг нь “холбогдох” гэсэн утгатай хийгээд йогийн систем нь биднийг трансцендент ертөнцтэй холбоо тогтоолгоход зориулагдсан байдаг. Өмнөх бүлэгт өгүүлсэнчлэн, анхнаасаа л бид Дээд Бурхантай холбоотой ч харин энэ цаг үед бид материтай холилдон зууралдсанаар бохирдон бузардсан юм. Бидний даалгавар бол буцаад бурханлаг сүнсний ертөнц рүүгээ харьж очих явдал хийгээд түүнтэй холбогдох аргачлалыг йог хэмээн нэрийдмүй. Мөн йог хэмээх үг нь “эерэг” гэсэн өөр нэг утгыг илэрхийлдэг. Орчин үед бид “сөрөг Бурхан” гэж ярьдаг буюу өөрөөр хэлбэл Бүхний Дээдтэй ямар ч холбоо харьцаагүй гэж ярьцгаадаг. Харин бид өөрийн амьдрал дээрээ Бурханыг, Кришнаг нэмбэл хүний бие махбодийг олж төрсөн бидний амьдрал төгс төгөлдөр болно.

Үхэх мөчдөө бид энэхүү өөрийгөө төгөлдөржүүлэх үйл явцаа дуусгах ёстой. Биднийг төгс төгөлдөрт хүргэх аргачлалд бүхий л амьдралынхаа туршид дадлагажих нь чухал. Тэгснээр бид, бие махбодио орхих үхлийн тэр эгзэгтэй мөчид төгс төгөлдөрт хүрч чадна.

*прайана – кале манаса` чалена
бхактия йукто йоги-балена чаива
бхрувор мадхье пранам авешиа самйак
са там парам пурушам упанти дивйам*

“Үхлийн торгон мөчид амьдралын агаараа хөмсөг хоорондоо аваачин, өөрийн бодол ухаанаа чин сүсэг бишрэлтэйгээр Дээд Бурхан дээр төвлөрүүлж чаднав, тэр хүн эргэлзээгүйгээр Дээд Бурханы бодгальд хүрмүй” (Бхагавад-гита, -8.10).

Оюутан хүн дөрөв, таван жил ямар нэг зүйлийг судлан суралцаад дараа нь шалгалт өгснөөр эрдмийн цол зэрэгтэй болдог шиг бидний амьдралд ч ийм зүйл тохиолдох болно: хэрэв бид үхлийн эгзэгтэй мөчид авах тэр шалгалтанд бүхий л амьдралынхаа туршид бэлтгэсэн бол энэ шалгалтыг даван гарч бурханлаг сүнсний ертөнц рүү өгсөн одмуй. Үхлийн мөчид бидний бүхий амьдрал шалгагддаг.

*йам йам вапи смаран бхавам
тйаджати анте калеверам
там там эваити каунтейа
сада тад-бхава-бхавитах*

“Бие махбодио орхих агшиндаа хүмүүн, ахуйн ямар хэлбэрийг дурсан сананав, тэрвээр энэ хэлбэрийг гарцаагүй хүлээн авмуй” (Бхагавад-гита, -8.6).

Хүмүүний төгс төгөлдөрт хүрэхээр зорьж хийсэн бүхэн нь үхэх мөчид шалгагдую гэсэн бенгали ардын зүйр цэцэн үг байдаг. “Бхагавад-гита”-д Кришна, биеэ орхихдоо юу хийх хэрэгтэй тухай зөвлөн айлдсан байдаг. Дхйана-йогчдод/бясалгалаар хичээллэгсэд/ хандан, Шри Кришна дараахь сургаалыг айлдсан юм:

*йад акшарам веда-видо ваданти
вишанти йад йатйао вита-рагах
йад иччханти брахмачарйам чаранти
тат те падам санграхена правакшиё*

*сарва – дварни самйамйа
mano хрди нирудхйа ча
мурдхни адхайатманах пранам
астхито йога-дхаранам*

“Огоорлын амьдралын хэв маягийг мөрдөн, Ведүүдийг танин ойлгож, омкараг-г дуудагч их мэргэд нь Брахманд ормуй. Тийм төгс төгөлдөрт хүрэхийн тулд тэд гэр бүлгүй байх сахил хүртдэг болой. Түүний туслалцаатайгаар авралд хүрч болох тэрхүү аргын тухай Би чамд айлдсу. Йогчдын төлөв байдал нь мэдрэхүйн бүхий л үйлээс огоорсон тэр төлөв байдал хийгээд мэдэрхүйн бүхий л үүд хаалгаа хааж, ухаанаа зүрхэндээ төвлөрүүлэн амьдралын агаараа толгойн дээд хэсэгтээ аваачсанаар хүмүүн йогтоо батаждаг бүлгээ” (Бхагавад-гита, -8.11-12).

Йогийн системд энэхүү үйл явцыг пратйахара гэдэг ба энэ нь “шууд эсрэг орших” хэмээсэн утгатай. Бүхий л амьдралынхаа туршид бид газар дэлхийн үзэсгэлэнг гөлрөн ширтэвч үхлийн мөчдөө тийм объектуудаас мэдрэхүйгээ салган авч дотоод гоо үзэсгэлэнгээ толидох хэрэгтэй. Үүнтэй адил, бидний чих дэлхийг дүүргэсэн дуу авиадыг сонсох зуршилтай ч үхэх агшиндаа дотор эгшиглэх трансцендент авиа *омкара* – г сонсох хэрэгтэй юмаа.

*om iti экакшарам брахма
вйахарам мам анусмаран
йах прайати тйаджан дехам
са йати парамам гатим*

“Үсгүүдийн дээд хослол ариун авиа ом – г дуудан йогт оршиж, Дээд Бурханы Бодгалийг төвлөрөн бодогч хүмүүн нь биеэ орших агшиндаа эргэлзээ үгүйгээр бурханлаг сүнсний гаригт хүрмүй” (Бхагавад-гита, -8.13).

Ийм байдлаар Бурханы хэлбэр дүр, *вишну-муртид* анхаарлаа төвлөрүүлэхийн тулд бүхий л үйлийг таслан зогсоож, тэднийг зөв зүйтэй ашиглах хэрэгтэй. Ухаан санаа нь маш тогтворгүй хэдий ч харин түүнийг зүрхэндээ орших Бурхан дээр төвлөрүүлэх нь зүйтэй. Хүмүүн ухаанаа зүрхэндээ төвлөрүүлж, амьдралын агаараа толгойн дээд хэсэгтээ өгсүүлэн аваачсан цагт тэрбээр йогийн дээд төгс төгөлдөрт хүрч чадна.

Энэ мөчид йогч хаашаа явахаа шийдэж болмуй. Материаллаг орчлонгийн дотор үй олон гаригс байдаг хийгээд энэхүү орчлонгийн гадна талд бурханлаг сүнсний орчлон оршмуй. Йогчид эдгээр гаригуудын тухай ведийн бичээсүүдээс хэдийн мэдэх билээ. Америк орон руу одохын өмнө түүний тухай сонин номноос уншиж тэр улс орны талаар тодорхой төсөөлөлтэй болж болж болноо доо. Үүн шиг бурханлаг сүнсний гаригуудын тухай ведийн бичээсүүдийг уншсанаар мэдэж болно. Йогч нь ведийн бичээсүүдэд агуулагдаж буй өгүүлэмжээр эдгээр гаригуудын талаар бүгдийг мэддэг бөгөөд өөрийн сонголтоор ямар нэг сансрын хөлгийн туслалцаагүйгээр дурын гаригтаа хүрч чадмуй. Механик хэрэгслүүдийн тусламжтайгаар аялах сансрын аяллыг бусад гаригт хүрэх тохирсон арга хэмээн тооцох хэрэггүй юм. Хэд хэдэн хүн асар их цаг хугацаа, мөнгө хөрөнгө, хүч хөдөлмөр зарцуулан байж хийсэн материаллаг хэрэгслийн (сансрын хөлөг, скафандр гэх мэт) тусламжтайгаар харь гаригст хүрч болох ч энэ нь маш хүнд хүчир хийгээд урьд өмнө хэрэглэгдэж байгаагүй арга юм. Гэвч ямар ч тохиололд механик арга хэрэгслийн тусламжтайгаар материаллаг орчлонгийн хил хязгаарыг давах бололцоогүй билээ.

Дээд гаригуудад хүрэх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга нь бясалгалыг йог хийгээд *джнана* юм. Гэвч бхакти-йогийн аргачлал нь ямар нэг материаллаг гариг эрхэст хүрэхэд

зориулагдаагүй. Дээд Бурханд буюу Кришнад үйлчлэн зүтгэгчийн хувьд материаллаг ертөнцийн ямар ч гариг сонирхлыг нь татдаггүй хийгээд учир нь тэд материаллаг ертөнцийн ямар ч гаригт хүрлээ гэсэн хаа сайгүй амьд бодгалиуд нь төрдөг, өглөдөг, өвддөг, үхдэг гэдгийг мэдэж байдаг. Дээд эрэмбийн гаригс дээр амьдрах хугацаа нь манай Дэлхийнхээс илүү байж болох ч тэнд орших амьд бодгалиуд үхэх тавилантай.

“Материаллаг орчлон” дотор орших гаригсд бүхий л амьд бодгалиуд нь үхдэг, төрдөг, өвддөг, өглөдөг гаригууд хамаардаг хийгээд харин “бурханлаг сүнсний орчлон”-д орших гаригс дээр хэн ч үхдэггүй, төрдөггүй, өвддөггүй, өглөдөггүй. Оюун ухаант хүмүүсийн хувьд тэд материаллаг ертөнцийн хил хязгаар дотор тархан байрласан эдгээр гаригсын алинд нь ч очихоор тэмүүлдэггүй. Дээд эрэмбийн гаригууд руу ямар нэг механик хэрэгслийн тусламжтайгаар морилохыг санаархагчийг агшин зуурын үхэл хүлээж буй. Учир нь тухайн хүмүүний бие махбодь нь тухайн гаригийн агаар мандлын огцом өөрчлөлтийг тэсвэрлэдэггүй. Харин тэрбээр дээд эрэмбийн гаригууд руу бясалгалын йогийн аргаар очихыг хүсвэл тэрээр түүнд тохирсон бие махбодийг хүлээж авмуй. Үүнийг энэ дэлхий дээр ч харж болно: усны амьтад хуурай газар амьдарч чаддаггүй шиг хуурай газрын амьтад усанд амьдарч чаддаггүй. Тэр ч атугай энэ гаригс дээр ч тодорхой газар нутагт амьдрахын тулд тодорхой хэлбэрийн биетэй байх шаардлагатай болж байна. Дээд эрэмбийн гаригуудад амьдрах хугацаа нь манай дэлхийнхээс хавьгүй илүү бөгөөд учир нь дээд гаригуудын нэг өдөр нь манай дэлхийн зургаан сартай тэнцдэг. Ведүүдэд өгүүлснээр дээд гаригийн оршин суугчид дэлхийнхээр арван мянга орчим жил насладаг гэжээ. Тэр ч байтугай хэн нэг нь хорин мянга, тавин мянга бүр хэдэн сая жил насладаг ч ялгаагүй л бидний амьдрах хугацаа хязгаартай хийгээд үхэх нь зайлшгүй. Тэгвэл хэрхэн үхлийн савраас ангижирч болох вэ? Энэ тухай “Бхагавад-гита”-д:

*на джайате мрийате ва кадачин
найам бхутва бхавита ва на бхуйах
аджо нитйах шашвата`йам пурано
на ханйате ханйамане шарире*

“Сүнс нь төрөлт болоод үхлийг мэддэггүй. Тэрээр хэзээ ч үүсэн бий болоогүй хийгээд устаж үгүй болдоггүй. Тэрбээр төрөөгүй хийгээд мөнх, анхдагч, үргэлж оршин байдаг. Тэрээр бие махбодь нь үхэж мөхөхөд хамт үхдэггүй амой” (Бхагавад-гита, -2.20)

Бид бурханлаг сүнснүүд учраас мөнх юм. Гэвч тэгвэл яагаад бид төрж, үхнэ вэ? Иймэрхүү асуулт тавьж буй хүмүүнийг ухаалгаас ухаалаг хүн гэж тооцох хэрэгтэй. Харин Кришнаг ухамсарлагч нь хүмүүсийн дотроос хамгийн ухаалаг нь бөгөөд учир нь тэрээр үхэл зовлон хүлээж буй гариг эрхэст морилохоор тэмүүлдэггүй. Тэд Бурхантай адилхан бие махбодийг олж авахын тулд урт удаан амьдралаас татгалздаг. *Ишварах парамас кришнах сач-чид-анада-виграхах. Сат* гэдэг нь “мөнх”, *чит* нь “мэдлэгээр дүүрэн”, *ананда* нь “аз жаргалаар бялхсан”. Кришна нь дээдийн дээд цэнгэлийн үндэс юм. Материаллаг бие махбодио орхиж сүнсний ертөнцийн Кришналока гаригт /Кришнагийн орших гариг/ юмуу эсхүл өөр нэг сүнсний гаригт хүрч очсоноор бид мөн *сач-чид-ананда* бие махбодийг хүлээн авна. Иймэрхүү байдлаар Кришнагийн ухамсарт оршигч болоод материаллаг ертөнцийн дээд эрэмбийн гаригст морилохоор санаархагч нар нь өөр, өөр зорилго өмнөө тавьдаг.

“Би” буюу өөрөөр хэлбэл хүмүүний сүнс нь өчүүхэн жижиг сүнсний оч юм. Энэхүү сүнсний очоо толгойнхоо дээд хэсэгт хүртэл өгсүүлснээр йогч нь төгс төгөлдөрт хүрдэг гэж тооцдог. Энэ түвшинд хүрснээр йогч нь өөрийн сонголтоор материаллаг ертөнцийн дурын гаригт аялаж чадна. Хэрэв йогч Сар гэж чухам юу болохыг мэдэхийг хүсвэл тэрээр энэ гаригт морилж болох хийгээд хэрэв дээд эрэмбийн гариг сонирхлыг нь татвал тэрээр

мөн тийш одож болох юм. Тэрээр үүнийг жирийн нэг аялагч Нью-Йорк, Канад болон дэлхийн дурын ямар ч улс орон руу нисэн оддог шиг хялбархнаар үйлдэж болмуй. Дэлхийн аль ч өнцөг буланд одсон хаа сайгүй визийн болоод гаалийн хяналт шалгалт үйлчилдэг болохыг харж болно. Үүн шиг бүхий л материаллаг гаригуудад нэг л хууль үйлчилдэг буюу бүхий л амьд бодгалиуд төрдөг, өтлөдөг, өвддөг, үхдэгт бат ноттой үнэмших болно.

Ом ити экакишарам брахма - үхэх мөчдөө йогч нь трансцендент авиадын хураангуйлсан хэлбэлзэл *омкара* авиа *ом* - г дууддаг. Хэрэв энэ мантраг дуудахдаа тэрбээр Кришна буюу Вишну (мам анусмаран) дурсан бодвол тэрээр дээд төгс төгөлдөрт хүрнэ. Энэ нь ухаанаа Вишну дээр төвлөрүүлэх йогийн аргачлал юм. Имперсоналистууд, Дээд Бурханыг ямар нэг хэлбэртэйгээр хийсвэрлэн төсөөлдөг байхад персоналистууд Түүний дүр хэлбэрийг ухаандаа зурагладаггүй харин ч Түүнийг нүүр тулан хардаг. Гэвч Түүний хэлбэрийг төсөөлнө үү, эсхүл үнэхээр олж харна уу, энэ нь ач холбогдолгүй хийгээд хамгийн чухал нь ухаанаа Кришнагийн бодгаль хэлбэр дээр төвлөрүүлэх хэрэгтэй.

ананйа - четах сататам

йо мам смарати нитйашах

тасйахам сулабхах партха

нитйа – йуктасйа йогинох

“Хэн бээр өөр юунд ч үл сатааран Миний тухай үргэлж боднов, ай Притхийн хүү минь ээ, тэрээр Надад байнгын чин бишрэлээр үйлчлэн зүтгэж байгаа тул тун хялбархнаар Надад хүрмүй ” (Бхагавад-гита, - 8.14).

Хэн бээр өөрийн энэ цаг зуурын амьдралыг түрхэн зуурын жаргал цэнгэл, цаг зуурын ая тухтай байдлаар цогцлоон зохиовол тийм хүмүүнийг ухаалаг хүн гэж тооцох хэрэггүй бөгөөд наанадаж “Бхагавад-гита”-д ийнхүү өгүүлсэн байдаг. “Гита”- д өгүүлснээр, зөвхөн мөхөс ухаант хүмүүн нар нь цаг зуурын цэнгэл жаргалд татагддаг гэжээ. Бид мөнх атал юуны тулд цаг зуурын цэнгэл таашаалыг сонирхох ёстой юм бэ? Энэ ертөнцөд бүгд л байнгын, мөнхийн зүйлийг эрж хайдаг. Хэрэв бид байр хөлсөлдөг бол гэрийн эзэн биднээс нүүхийг хүсэж болно шүү дээ. Тэгвэл, бид мэдээж үүнд нь баярлахгүй. Гэвч биднийг, нүүснээр илүү сайхан байр сууц хүлээж буй бол бид харамсан гуниглахгүй. Бид мөн чанартаа мөнх бөгөөд тийм ч учраас байнгын өмөг түшгийг эрж хайж байдаг. Бид үхэхийг хүсдэггүй. Учир нь бид мөнх. Үүний адил бид өтлөж, өвдөхийг хүсдэггүй ба учир нь энэ бүх төлөв байдал цаг зуурын зэрэгцээ бидний гадаад бүрхүүлд хамаардаг. Чичрэг туссан төлөв нь хэвийн байдлаас гажуудсан байдал ч заримдаа бид халуурдаг. Тэр үед эрүүлжихийн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахын зэрэгцээ эм уух хэрэгтэй болдог. Дээрх дөрвөн янзын зовлон зүдгүүр нь ийм чичрэгтэй адил юм. Тэд бүгдээрээ материаллаг бие махбодид оршин буйтай нөхцөлдсөн байдаг. Зөвхөн хэрэв бидэнд материаллаг биеэс ангижирах аз тохиовол бие махбодид оршин буйтай холбоотой зовлон шаналалуудаас хагацаж болно.

Хэврэгхэн материаллаг бие махбодиос ангижирахыг хүссэн имперсоналистуудад Кришна, *ом* хэмээх авиаг дуудахыг зөвлөжээ. Энэ тохиолдолд тэд сүнсний ертөнцөд морилох нь гарцаагүй юм. Гэвч хэдий тэд сүнсний ертөнцөд орж чадах ч харин аль нэг гариг дээр буун заларч чадахгүй билээ. Тэд *брахмаджйотид* саатсанаар тэдгээр гаригст хүрдэггүй. *Брахмаджйотийг* нарны гэрэлтэй адилтгаж болох бөгөөд харин сүнсний гаригуудыг нартай өөртэй нь зүйрлүүлж болмуй. Бурханлаг сүнсний тэнгэрт, имперсоналистууд *брахмаджйоти* буюу гэрэл туяанд үлддэг. Тэд сүнсний оч хэлбэрээр *брахмаджйотид* үлддэг бөгөөд тэдгээр очуудаас *брахмаджйоти* бүрдмүй. Сүнсний ахуйтай нэгдэх тухай ярьж байвал чухамхүү ингэж ойлгож болно. *Брахмаджйотитой*

нэгдэнэ гэдгийг амьд бодгаль нь түүнд уусан шингэнэ хэмээн ойлгож болохгүй. Сүнсний оч нь өөрийн тусгаар байдлаа хадгалж үлддэг ч имперсоналист нь бодгаль, биет хэлбэр төрхийг хүлээж авахыг хүсдэггүй учир энэхүү гэрэл туяанд сүнсний оч хэлбэрээр үлддэг. *Брахмаджйоти* нь олон жижиг хэсгээс бүрдэх нарны гэрэлтэй адил бөгөөд олон тооны сүнсний очуудаас тогтмуй.

Гэвч амьд бодгалиуд бид цэнгэн жаргахыг хүсдэг. Бидэнд зүгээр л оршин байх нь ер хангалттай биш. Бид оршин байхыг (*sat*) хүсдэг төдийгүй аз жаргалыг (*ананда*) амссахыг хүсдэг. Өөрийн бүхэл бүтэн чанарын хувьд амьд бодгаль нь гурван чанар байдлын (мөнх, мэдлэг, аз жаргал) цогц юм. Хэн бээр бодгаль бус хэлбэр төрхийг хүлээн авч *брахмаджйотид* нэгдэн орнов, тэрбээр Брахмантай нэгдсэн гэдгээ бүрнээ ухамсарлавч мөнхийн *ананда* буюу аз жаргалд хүрч чадахгүй. Учир нь энэ төлөв байдалд ийм шинж чанар байдаггүй. Тодорхой цаг хугацаанд өрөөндөө ганцаар сууж ном уншиж, элдвийн зүйл эргэцүүлэн сууж болох ч хэн ч ингэж өрөөндөө хэдэн жилийг элтэл сууж чадахгүй агаад энэ нь тэнд мөнхөд орших боломжгүй гэсэн үг. Ийм учраас өөрийн бодгаль хэлбэрээ алдаж Бүхний Дээдтэй нэгдэгч нь бусадтай харьцахын тулд материйн ертөнцөд хэзээд дахин унаж болно. Ингэж “Шримад-Бхагаватам”-д батлан айлдсан буй. Сансрын нисэгчид мянга, мянган жил нисээд ч хэрэв тэд газардах гариг эрхсийг олж чадахгүй бол буцаад газар дэлхийдээ эргэн ирэх хэрэгтэй болно. Ямар ч л гэсэн хүмүүнд гэр орон зайлшгүй чухал. Бодгаль бус хэлбэр дэхь амьд бодгалийн байр суурь тогтвортой бусаа. Ийм ч учраас “Шримад-Бхагаватам”-д өгүүлснээр, ихээхэн хүчин чармайлтыг гаргаснаар имперсоналистууд нь сүнсний ертөнцөд хүрч бодгаль бус хэлбэрийг олж авч болох хэдий ч тэрээр тэнд Дээд Бурханд чин бишрэл зүтгэл ба хайраар үйлчлэхгүйн учир хэзээ нэгэн цагт дахин материйн ертөнцдөө буцан ирмүй хэмээжээ. Бид энд, эх дэлхий дээр байх цагтаа л Дээд Бурхан Кришнаг хайрлахад суралцах ёстойн дээр мөн хэрхэн Түүнд үйлчилдэг тухайд суралцах нь зүйтэй юм. Хэрэв бид үүнд суралцаж дадлагажвал сүнсний гаригт морилон очиж чадна. Сүнсний ертөнц дэхь имперсоналистийн байр суурь тогтворгүй бөгөөд учир нь ганцаардах мэдрэмж нь түүнийг харьцаж болох нэгнийг эрүүлж хайлгуулж эхэлдэг. Тэрээр Дээд Бурхантай нүүр тулан харьцах боломжгүй учраас энэ ертөнц рүү эргэн ирж энэ болзолт амьд бодгалиудтай харьцах болдог.

Ийм учраас бид өөрсдийн анхдагч байр сууриа мэдэх нь чухал. Өөрөөр хэлбэл биднийг үхэлгүй мөнх, бүхий эрдэм мэдлэг, аз жаргалд дуудах бидний мөнхийн тэмүүллийг тодорхойлох өөрсдийн уг мөн чанараа мэдэх хэрэгтэй. Гав ганцаар, удаан хугацааны туршид бодгаль бус *брахмаджйотид* байснаар бид цэнгэн жаргах боломжоо алдах ба цэнгэл жаргал эдлэхийн тулд материйн ертөнц рүү буцдаг. Гэвч Кршнагийн ухамсрыг олж хүртвэл бид жинхэнэ ёсоор цэнгэл жаргалыг эдлэх болно. Материйн ертөнцөд дээдийн дээд цэнгэл таашаал нь эр, эмийн харьцаа гэдгийг бүгд хүлээн зөвшөөрдөг. Энэ цэнгэл нь Кришнатай харьцах цэнгэл таашаал буюу сүнсний ертөнц дэхь эр, эмийн цэнгэл таашаалын гажуудсан тусгал юм. Гэвч тэнд амтлах цэнгэл нь материйн ертөнц дэхь эр эмийн цэнгэлтэй адил мэтээр эндүүрэн бодох хэрэггүй. Үгүй, энэ нь огтхон ч адил бус. Гэвч хэрэв сүнсний ертөнцөд л бэлгийн амьдрал байдаггүй бол тэрээр энд ч байхгүй байхсан. Энд зөвхөн түүний гажуудсан тусгал л оршдог ба жинхэнэ амьдрал бол хязгааргүй аз жаргалаар дүүрэн Кришнатай амьдрах явдал юм. Ийм учраас хамгийн зөв зүйтэй алхам нь үхэх агшиндаа сүнсний ертөнц буюу Кришналокад морилон очиж, Кришнатай нүүр тулан харьцах боломж олж авахын тулд яг одоо л эхлэх нь зүйтэй. “Брахма-самхита”-д (5.29) Шри Кришна болоод Түүний орших өлгий нутгийн тухай:

*чинтамани – пракара – садмасу – калпа – вркиша
лакшавртешу сурабхир абхипалайантам
лакшми – сахасра – шата – самбхрама – севйаманам*

“Би бээр бүхий л амьд бодгалиудын өвөг эцэг болсон анхдагч Бурхан Говинда танаа сөгдөн мөргөнөм. Тэрбээр сая, сая хүслийн ой модоор хүрээлэгдсэн, гүн ухааны чулуудаас бүтсэн Өөрийн орондоо заларч бүхий хүслийг биелүүлэхийн сацуу *сурабхи* үнээд хариулан суух авай. Мянга, мянган *лакшми* хийгээд *гопи* нар Түүнд чин бишрэл ба хайраар үргэлжид үйлчилмүй”. Энэ бол Кришналокагийн дүр зураг. Тэнд орших гэр байшин нь гүн ухааны гэж нэрлэгдэх чулуудаар хийгдсэн байдаг. Гүн ухааны чулуунд юу ч хүргэсэн тэд бүгд шууд алт болон хувирмуй. Тэнд ургадаг моддыг “хүслийн мод” буюу хүслийг биелүүлэгч модод гэдэг. Учир нь тэд ямар ч хүслийг гүйцэлдүүлж чаддаг. Энэ ертөнцөд бол мангогийн модонд манго л ургадаг, алимны модонд алим л ургадаг байхад харин тэнд ямар ч мод хүссэн жимс болгоныг чинь өгөх болно. Тэнд орших үнээдийг *сурабхи* хэмээх ба тэд хэмжиж баршгүй сүү хайрладаг. Ведүүдэд сүнсний гаригуудын талаар ийн өгүүлсэн байдаг.

Материйн ертөнцөд бид хэдийнээ үхэх, төрөх хийгээд бүхий л төрлийн зовлон, гасланд дасаж гүйцжээ. Материалист – эрдэмтэд мэдрэхүйн цэнгэлийн тулд олон, олон арга хэрэгсэл зохион бүтээсний дээр олон, олон сөнөөн устгах багаж зэвсэг зохиож байна. Гэвч тэд үхэх хийгээд өвдөх, өтлөх асуудлуудыг шийдвэрлэх аргаа олоогүй хийгээд тэд өвдөх, өтлөх, үхэхийг зогсоох машин тэрэг зохиочихож чадахгүй. Бид үхлийг ойртуулах л зүйлийг хийж чадахаас түүнээс ангижирчих юуг ч хийж бүтээж чадахгүй билээ. Гэвч жинхэнэ ухаалаг хүмүүн нар материаллаг амьдралын энэ дөрвөн асуудлыг шийдэх гэж оролддоггүй. Харин тэднийг сүнсний ертөнцөд аваачих зам мөрийг л хайж байдаг. Трансын */нитиа –йуктасиа йогинох/* төлөвт оршигч хүмүүн нь орчин тойрны юунд ч автдаггүй. Тэрээр үргэлжид трансын төлөвт орших хийгээд байнгад Кришнагийн тухай бодолд автаж, өөр юунд ч анхаарал нь татагддаггүй/*ананья четах сататам/*. *Сататам* нь “хаа сайгүй” хэмээсэн утгатай.

Энэтхэгт би Вриндаванад амьдарч байсан, одоо Америкт оршин байгаа ч энэ нь би Вриндаванаг орхисон гэсэн үг бишээ. Учир нь хэрэв би байнгад Кришнагийн тухай бодвоос би хаана байгаагаас үл хамааран үргэлжид Вриндаванд орших болно. Хэн бээр Кришнагийн ухамсрыг өөртөө хөгжөөнөм бэ, тэрээр үргэлжид сүнсний гариг Голока Вриндавана дээр Кришнатай хамт байж, өөрийн материаллаг бие махбодио орхих тэр л мөчийг хүлээмүй. *Смарати нитйашах* нь “байнгад дурсан санах” гэсэн утгатай. Хэн Кришнагийн тухай байнгад боднов, Бурхан түүний хувьд хялбархан хүрчихэж болох буюу *тасйахам сулабхах* болдог. Кришна Өөрөө, Түүнд бхакти-йогийн аргачлалын тусламжтайгаар хялбархан хүрч болно хэмээн айлджээ. Тэгвэл юуны тулд өөр бусад аргачлалд хандах хэрэгтэй юм бэ? Бид: Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама, Харе Харе – г байнгад давтан уншиж чаднаа даа. Үүний тулд даган баримтлах хатуу дэг жаяг байхгүй бөгөөд түүнийг гудамжинд ч, метронд ч, гэртээ эсвэл ажил дээрээ ч уншиж болно. Үүнийг хийхэд ямар ч татвар төлөхгүй, ямар нэг мөнгө төгрөг зарцуулахгүй. Тэгвэл яагаад энэ аргыг ашиглаж болохгүй гэж ?

Материйн ертөнц хэмээх шорон гяндангаас ангижирахуй

Джнани нар болоод йогч нар нь яахын аргагүй имперсоналистууд бөгөөд тэд сүнсний тэнгэр буюу цацраг туяанд нэгдэн цаг зуурын ангижралд хүрч болох ч “Шримад-Бхагаватам”-д батлан айлдсанаар, тэдний мэдлэгийг цэвэр тунгалаг гэж тооцох аргагүй хэмээжээ. Өөртөө бэрхшээл зүдгүүр учруулан, тэвчил хийж, бясалгал үйлдсэнээр тэд Дээд Туйлд хүрч болох ч урьд тайлбарсанчлан Кришнагийн бодгаль төлөв байдлыг шууд хүлээн зөвшөөрөөгүйгээс дахин материйн ертөнцөд унадаг. Кришнагийн бадамлянхуан өлмийд хэн үл сөгдөн мөргөнө вэ тэрээр дахин материаллаг түвшин рүү уруудан доройтох хэрэгтэй болдог. Чухамдаа бид: “Би бол Таны мөнхийн зарц албат билээ. Танд ямар нэг хэлбэрээр үйлчилж зүтгэхийг болгоон соёрхоо” хэмээн бодож байх ёстой. Кришнаг *аджита* буюу ялагдашгүй гэж нэрлэдэг. Учир нь хэнбэгуай ч Бурханыг ялан дийлж чадахгүй. Гэвч “Шримад-Бхагаватам”-д Бурханы тухай тийн бодогч нь Бүхний Дээдийг хялбархнаар байлдан дагуулж чадмуй хэмээн батлан айлджээ. “Шримад-Бхагаватам”-д мөн Бүхний Дээдийг хэмжих цаг үрсэн чармайлт оролдлогоо орхигтун хэмээн бидэнд зөвлөсөн байна. Бид сансар огторгуйнхаа хил хязгаарыг хэмжиж ч чадахгүй байж Бүхний Дээдийг хэмжих тухай яриад ч яах билээ! Хүний эзэмшсэн хумсын чинээ мэдлэг нь Кришнагийн хэмжээ хязгаарыг мэдэхэд ер хангалтгүй хийгээд харин үүнийг ухамсарлсан хүмүүнийг Ведүүд ухаалаг хэмээн нэрлэдэг. Бид өөрсдийгөө орчлон доторх үл ажиглагдах өчүүхэн жижиг хэсэг гэдгээ хүлцэнгүйгээр хүлээн зөвшөөрөх ёстой. Өөрийн хязгаарлагдмал мэдлэг болоод ухааны цараагаар Бүхний Дээдийг ойлгох оролдлогоо орхин бид хүлцэнгүй номхноор, Бүхний Дээдийн өгүүлсэн нэр хүндтэй, бат ноттой эх сурвалжууд ялангуяа “Бхагавад-гита”-г хүүрнэж буй хүмүүнийг буюу өөрийн сүнсний мөн чанараа ухамсраласан хүмүүн нарыг сонсох ёстой юм.

“Бхагавад-гита”-д Арджуна, Шри Кришнагийн Өөрийнх нь хүүрнэсэн Бурханы тухай айлдварыг сонссоноор Бүхний Дээдийг ойлгохыг хүсэгч хүмүүн нь яах ёстойг өөрийн биеэр үлгэрлэн үзүүлсэн. Бид “Бхагавад-гита”-г Арджунын өгүүлсэнээр юм уу эсхүл түүний төлөөлөл номын багшийн айлдсанаар сонсон хүртэх ёстой. Тэднийг сонсоод олж авсан мэдлэгээ өдөр тутмынхаа амьдралд зөв зүйтэй ашиглах хэрэгтэй. Чин бишрэлтэн нь Бурханд хандан: “Бурхан минь ээ, Та ялагдашгүй билээ. Гэвч бат ноттой эх сурвалжуудыг сонсож амссанаар Таныг байлдан дагуулж чадах билээ” хэмээн мөргөн залбирдаг. Бурхан ялагдашгүй ч Бурханыг өөрийн ухааны хүчээр ойлгох оролдлогоо орхиж, нэр хүндтэй, бат ноттой эх сурвалжид хандсанаар чин бишрэлтэн нь Түүнийг байлдан дагуулж болох юм.

“Брахма-самхита”-д танин мэдэхүйн өгсөх ба уруудах гэсэн хоёр арга байдаг тухай өгүүлжээ. Өгсөх аргын хувьд хүмүүн нь эрдэм мэдлэгийг өөрийн хүчин чармайлтаар олж авдаг. Ийн ахуйдаа тэрээр: “Баттай эх сурвалжууд хийгээд номууд миний сонирхлыг үл татнам. Бясалгал болоод гүн ухааны эргэцүүлэл гэх мэтээр би мэдлэгийг өөрөө олж авна. Ингэж л би Бурханыг танин ойлгоно” гэж боддог. Уруудах арга гэдэг нь дээд баттай эх булгуудаас мэдлэгийг хүлээж авахыг хэлнэ. “Брахма-самхита”-д өгсөх аргаар хүн Бурханыг таниж чадахгүйн зэрэгцээ тэр ч бүү хэл энэ замаар бодол санаа болоод салхины хурдаар сая, сая жил замнаад ч тэр хүн Бурханыг таниж чадахгүй хэмээн батлан айлджээ. Танин мэдэхүйн объект нь түүний хувьд хүршгүй, ойлгогдошгүй хэвээр үлдэнэ. Гэвч энэ объектуудын тухай “Бхагавад-гита”-д: *ананья четах* хэмээн өгүүлсэн байдаг. Кришна айлдахдаа, чин бишрэл зүтгэлийн зам мөрөөс үл хазайн, сүнсний хүлцэнгүй төлөвт оршин Түүн дээр анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй хэмээжээ. Тэрээр, тиймэрхүү байдлаар сөгдөн мөргөсөн хүмүүн нь тун хялбрахнаар(*тасйахам сулабхах*) Түүнд хүрмүй гэж айлдсан

байдаг. Аргачлал ерөөсөө л ийм. Хэрэв хүн өөрийгөө Кришнад үйлчлэн зүтгэхэд зориулвал Кришна түүнийг хайхрахгүй орхихгүй, мартахгүй. Хүлцэнгүй байснаараа хүмүүн Бурханы анхаарлыг өөртөө татдаг. Бхактисиддхантa Сарасвати Гуру Махараджа: “Бурханыг харах гэж бүү хичээгтүн. Та Түнийг зүгээр л харахыг хүссэнээр Тэрээр зарц албат шиг таны өмнө гарч ирэх албатай гэж үү? Хүлцэнгүй номхон хүн нь тийм үйлийг хийдэггүй. Бид Түүнтэй хайр болоод бишрэл зүтгэлээрээ холбогдох ёстой” гэж байнга ярьдаг байлаа.

Чайтанья Махапрабху Бурхан хүн төрөлхтөнд Кришнад хүрэх үнэлж баршгүй аргачлалыг хайрласан ба Түүний анхны шавь Рупа Госвами үүнийг тун өндрөөр үнэлсэн юм. Рупа Госвами мусульманы засгийн газрын сайд байсан ч Чайтанья Махапрабхугийн шавь болохын тулд төрийн албыг орхисон билээ.

Рупа Госвами Бурхан дээр очин Түүнд сөгдөн дараахь шүлгийг айлтгажээ:

*намо маха - ваданайа
кришна – према-прадайа – те
кришнайа кришна - чайтанья
намне гаура - твише намах*

“Би Дээд Бурхан Шри Кришна Чайтанья танаа гүн хүндэтгэлтэйгээр сөгдөн мөргөмүй. Тэрээр бүхий л хувилгаадудаас бүр Кришнагаас Өөрөөс нь ч илүү уужим энэрэнгүй сэтгэлтэй бүлгээ. Учир нь Түүнээс урьд хэн ч, хэзээ ч өгч байгаагүй. Кришнаг хайрлах цэвэр тунгалаг хайрыг бүхэнд өгөөмрөөр хүртээдэг билээ”. Рупа Госвами, Чайтанья Махапрабхуг хамгийн өгөөмөр, хамгийн аугаа уужим сэтгэлтэн гэж нэрлэсэн юм. Учир нь Тэрээр орчлон ертөнц дээр хамгаас үнэтэй зүйл Бурханыг хайрлах хайрыг харамгүй түгээж байсан билээ. Бидэнд бүгдэд нь Кришна л дутагддаг хийгээд бид бүгд Кришнаг л хүсдэг. Тэрээр хамгийн дур татам, хамгийн үзэсгэлэнтэй, хамгийн баян, хамгийн хүчтэй, хамгийн мэргэн нь юм. Энэ бол хүн бүгдийн хүсдэг зүйл. Бид бүгдээрээ л эд баялаг, эрдэм мэдлэг, хүч чадал, гоо үзэсгэлэнг хүсдэг. Кришна-энэ бүгдийн эх үндэс. Иймээс бид өөрсдийн бүхий л санаа бодлоо Түүний зүгт хандуулвал бид хүсч тэмүүлсэн зүйлээ бүгдийг хүлээн авна. Бидний зүрх сэтгэл юуг хүслээ ч, хэрэв бид Кришнагийн ухамсрын зам мөрөөр замнаж буй бол тэр биелэх учиртай.

Урьд өгүүлсэнчлэн, Кришнагийн ухамсарт оршин ахуйдаа таалал төгссөн хүмүүн нь Кришнагийн оршин байдаг дээдийн орон Кришналокад шуудхан хүрдэг. Энэ гаригт хүрээд бид юу хожих юм бэ гэж хэн нэг нь асууж болох юм. Тэгвэл Кришна энэ асуултанд доорх хариултыг өгч байна:

*мам упетйа пунар джанма
духкхалайам ашашватам
напнуванти махатманах
самсиддхим парамам гатах*

“Эдгээр аугаа сүнснүүд, йогчид Миний чин бишрэлтэн нар нь зовлон гаслангаар дүүрэн энэхүү цаг зуурын ертөнцөд дахин хэзээ ч буцаж ирэхгүй. Учир нь тэд дээдийн дээд төгс төгөлдөрт хүрсэн бөлгөө” (Бхагавад-гита, -8.15).

Шри Кришна, бүтээгч Өөрөө энэ материйн ертөнцийг *духкхалайам* буюу зовлонгоор дүүрэн хэмээн батлан айлджээ. Бид энэ ертөнцийг цэнгэлийн талбар болгож чадах бил үү? Шинжлэх ухааны хөгжил дэвшил гэж нэрлэгдэх зүйлсийн тусламжтайгаар энэ ертөнц дээр тав тухтай амьдрах нөхцлийг бүтээн бий болгох боломжтой гэж үү? Үгүй, энэ нь огт боломжгүй. Гэвч бид үүнийг ойлгохыг хүсдэггүй. Тиймээс ч энэ ертөнцийн зовлон гаслан

нь ямар болохыг мэдэхийг хүсдэггүй. Урьд өгүүлсэнчлэн, эдгээр зовлон гаслан нь төрөх, өтлөх, өвдөх, үхэх ч эдгээр асуудлуудыг шийдвэрлэж чадахгүйгээс бид тэдгээрийг ажиглаагүй, мэдрээгүй юм шиг байхыг хичээдэг. Эрдэмтэд, биднийг цаг үргэлж дээрэлхэн тохуурхаж байна. Тэд эдгээр зовлон, гаслангуудад төсгөл тавьж чадахгүй. Үүний оронд харин тэд сансрын хөлөг, атомын зэвсэн үйлдвэрлэж бидний анхаарлыг сарниулдаг. Гэвч “Бхагавад-гита”-ийн энэ шүлгэнд эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж болох тухай өгүүлсэн байдаг: Хэрэв хүн Кришнагийн гаригт хүрвэл тэрээр үхэх, төрөхийн энэ ертөнц рүү дахин буцах ёсгүй. Бид энэ ертөнц нь зовлон зүдгүүрт гэдгийг ухамсарлах ёстой. Үүнийг ойлгохын тулд гайгүй сайн ухамсартай байх нь чухал. Муур, нохой, гахай нь зовж байна гэдгээ ойлгож чадахгүй. Хүмүүнийг оюун ухаант амьтан гэдэг ч тэрээр зовлонгоос ангижрах арга зам хайхын оронд оюун ухаанаа өөрийн адгуусны төлөв байдлыг хангахад ашигладаг. Харин Кришна, хэн Түүн рүү ирнэв, тэрээр хэзээ ч зовлонгоор дүүрэн энэ ертөнцөд дахин төрөхгүй хэмээн салаа утгагүйгээр батлан айлджээ. Түүн рүү хүрч очсон аугаа сүнснүүд нь амьд бодгалийг болзолт амьдралын зовлонгоос ангижруулахуй амьдралын дээдийн дээд төгс төгөлдөрт хүрдэг.

Энгийн амьд бодгалийн Кришнагаас ялгарах гол онцлог нь тэд цаг хугацааны тодорхой мөчлөгт нэг л газраа байсаар байдаг бол Кришна орчлонгийн аль ч өнцөг буланд оршиж чадахын зэрэгцээ Өөрийн гаригтаа мөн зэрэг оршин байж чаддаг. Трансцендент ертөнц дэхь Кришнагийн гаригийг Голока Вриндавана хэмээн нэрлэдэг. Энэтхэгт орших Вриндавана нь дэлхий дээр буун морилсон мөн л тэр Вриндавана юм. Өөрийн дотоод хүчээр Кришна Өөрөө энэ дэлхийд залрахад Түүний *дхама* буюу гариг орон нь Түүнтэй хамт буун залардаг. Өөрөөр хэлбэл Кришна дэлхий дээр буувал Тэрээр чухам энэ газар нутагт оршин байна гэсэн үг. Гэсэн хэдий ч Кришнагийн өлгий нутаг нь Ваикунтхийн трансцендент ертөнцөд мөнхөд оршдог. Энэ шүлгэнд Кришна, Ваикунтхад оршигч Түүний өлгийн нутагт хүрэгч нь дахин материйн ертөнцөд төрөхгүй хэмээн зарлан тунхаглажээ. Тийм хүмүүнийг *махатма* гэж нэрлэдэг. Баруунд *махатма* хэмээх үгийг Махатма Ганди гуайн нэртэй хольж хутган хэрэглэдэг ч *махатма* хэмээх үг нь ямар нэг улс төрийн зүтгэлтний цол гуншин биш гэдгийг бид ойлгох ёстой юмаа. *Махатма* гэдэг нь Кришнагийн ухамсрын зам мөрд дээдийн дээд төгс төгөлдөрт хүрсэн, Түүний гаригт морилох эрхийг олж авсан хүмүүнийг хэлдэг. Үхэх төрөхийн тойргоос ангижран гарахын тулд өөрийн хүний амьдралын хэлбэр, байгалийн баялагийг зөв зүйтэй ашиглагч хүмүүн нь *махатма* болдог.

Ухаалаг хүн, зовлог гаслан түүний дур хүслээс гадуур ирдэг гэдгийг мэддэг. Дээр өгүүлснээр, бид байнгад зовж зүдэрнэм: Бидэнд бидний ухаан, бидний бие махбодь, өөр бусад амьд бодгалиуд, мөн байгалийн гамшиг зовлон авчирдаг. Бидэнд зовлон учруулах зүйл үргэлж л байж байдаг. Энэ материйн ертөнц нь зовж зүдрэхэд л зориулагджээ. Энд зовлон байгаагүйсэн бол бид Кришнагийн ухамсрыг олж авахгүй л байхсан. Үнэндээ бол зовлон зүдгүүр нь биднийг Кришнагийн ухамсрын түвшинд хүргэх өдөөгч цэг юм. Ухаалаг хүмүүн нь, яагаад тэрээр өөрийн дур тааллын эсрэг зовлон гасланг амсах болдог тухай асуудаг. Орчин үеийн соёл иргэншилт гэж нэрлэгдэх хүмүүн нь: “Би зовбол зовж л байг, архи, мансууруулах бодисынхоо тусламжтайгаар би бүгдийг мартана” хэмээн боддог. Гэвч мансуурал нь гармагц зовлон гаслан нь буцаад л ирнэ. Тиймэрхүү зохиомол аргууд материаллаг амьдралын мөн чанар болсон зовлонгоос ангижруулж чадахгүй. Түүнээс ангижрах цорын ганц арга бол Кришнагийн ухамсарт хандах юм.

Зөвхөн Кришнагийн чин бишрэлтэн нар л Кришнагийн гаригт хүрэхээр тэмүүлдэг байхад бусад бүхий л хүмүүс Саран дээр морилохыг хүсдэг болохыг хэн нэг нь ажиглаж болох юмаа. Сар өөд нисэх нислэгийг мөн л ололт, дэвшилттэй гэж тооцох хэрэггүй гэж үү? Харь гаригст аялах дур сонирхол нь амьд бодгалиудад угаас бий юм. Амьд бодгалиудын тодорхойломжуудын нэг *сарва-гата* хэмээхүй нь “тэрбээр хаа сайгүй

аялахыг хүсдэг” хэмээсэн утгатай. Аялах дур сонирхол нь амьд бодгальд байгалиас заяасан байдаг. Саран дээр морилох гэсэн хүсэл нь ямар нэг шинэ зүйл бишээ. Йогчид мөн л дээд эрэмбийн гариг эрхэст морилохыг хүсдэг ч Кришна “Бхагавад-гита”-д (8.16) айлдахдаа ийм үйлдэл нь ямар ч ашиг тус үгүй хэмээжээ.

*абрахма - бхуванал локах
пунар авартино`рджуна
мам упетйа ту каунтейа
пунар джанма на видйате*

“Материйн ертөнцийн хамгийн дээрээс эхлээд хамгийн доор орших бүхий л гаригс нь үхэлт, төрөлт ээлжлэн давтагдаж байдаг зовлон гаслангийн өлгий бөлгөө. Гэвч Миний орших газар орноо хүрсэн хүмүүн нь, ай Кунтийн хүү минь ээ, дахин хэзээ ч төрөхгүй бүлгээ”. Орчлон нь дээд, дунд, доод гариг эрхсийн системүүдэд хуваагддаг. Кришна, орчлонгийн хамгийн дээд эрэмбийн гариг Брахмалока дээр ч үхэлт, төрөлт ээлжлэн байдгийг онцлон тэмдэглэжээ. Орчлон дахь бүхий л гариг эрхэс нь амьд бодгалиудаар дүүрэн билээ. Бид, манай гариг дээр л амьдрал бий бөгөөд бусад гаригс дээр амьдрал үгүй гэж бодох учиргүй. Дэлхийн аль ч өнцөг буланд амьд бодгаль үгүй газар нутаг үгүй болохыг төвөггүй нотлож болно. Газрын гүнд бид өт хорхойг олж харж болох ба усны гүнд загас жараахай, өөр бусад амьтсыг харж болох бөгөөд тэнгэрт бид үй олон шувуудыг олж харж болно. Тэгэхээр бусад гаригс дээр амьд бодгалиуд үгүй гэж хэрхэн дүгнэлт хийж болох билээ? Харин Кришна, аугаа их сахиулсан тэнгэрүүд амьдарч буй тэр гаригст хүрлээ ч ялгаагүй бид үхэх тавилантай тухай айлджээ. Түүнчлэн Тэрээр Түүний гариг эрхэст хүрсэн амьд бодгаль нь дахин төрөх шаардалагагүй болдог тухай батлан өгүүлсэн байна.

Бид аз жаргал, эрдэм мэдлэгээр дүүрэн мөнхийн амьдралд хүрэхийг чин сэтгэлээсээ хүсэх ёстой. Энэ л бидний амьдралын зорилго, бидний жинхэнэ хожил гэдгийг бид мартжээ. Яагаад бид энэ тухай мартчихсан юм бэ? Яагаад гэвэл бид хичнээн өндөр барилга барилаа ч, бид энд мөнх амьдарч чадахгүй нь ойлгомжтой хэдий ч материаллаг ертөнцийн өнгө гэрэл, түүн дээр орших тэнгэр баганадсан байшингууд, аварга том үйлдвэрүүд улс төрийн ил далд явуулга бидний дур сонирхлыг татсан юм. Бид өөрсдийн эрч хүчээ хүнд үйлдвэрүүд барих, хот байгуулах зэрэгт зарцуулах ёсгүй бөгөөд тийм үйл нь биднийг материаллаг байгалийн торонд улам, улам уядаг. Бид өөрсдийн эрч хүчээ, өөртөө Кришнагийн ухамсрыг хөгжүүлэх, мөн Кришнагийн гаригт морилж чадах сүнсний биеийг олж авах зэрэгт зориулах хэрэгтэй. Кришнагийн ухамсар бол ямар нэг шашны ягшмал номлол биш. Кришнагийн ухамсар бол амьд бодгалийн хамгийн чухал бүрдмэл хэсэг юмаа.

Орчлонгийн гадна орших тэнгэр

Хэрэв энэхүү орчлонгийн дээд эрэмбийн гаригст үхэлт, төрөлт оршин байдаг юм бол чухам яагаад аугаа их йогчид тэрхүү гаригст хүрэхийг тэмүүлнэ вэ? Эдгээр йогчид нь олон янзын гоц чадварыг эзэмшсэн байдаг ч тэдэнд өнөөх л материаллаг амьдралын эд баялагаар цэнгэх хүсэл нь үлдсэн байдаг. Дээд эрэмбийн гаригс дээр амьдрах хугацаа нь хэмжээ хязгааргүй их юм. Шри Кришна, эдгээр гаригст цаг хугацаа хэрхэн тоологддогийг:

*сахасра – йуга – парйантам
ахар йад брахмано видух
ратрим йуга – сахасрантам
те`хо – ратра – видо джананх*

“Дэлхийн тооллын мянган галав нь Брахмын нэг өдөртэй тэнцмүй. Мөн тийм хугацаатайгаар Брахмын шөнө үргэлжилмүй” (Бхагавад-гита, -8.17) хэмээн учирлан тайлбарлажээ.

Нэг галав нь /йуга/ 4300000 жил байдаг. Түүнийг 1000-аар үржүүлээд гарсан жил нь Брахмалокийн гариг дээрх Брахмын 12 цагтай тэнцдэг. Түүний шөнө мөн ийм 12 цаг байдаг. Ийм 30 өдөр нь нэг сарыг бүрдүүлдэг бөгөөд нэг жил нь ийм 12 сараас тогтдог. Брахма тийм 100 жил амьдардаг. Эдгээр гаригст амьдрагчид нь маш урт удаан амьдардаг. Гэвч мөн л триллион, триллион жил амьдраад ч Брахмын оршин суугчид үхэх л ёстой болдог. Бид сүнсний гариг эрхэст хүрээгүй цагт үхэл биднийг хаа сайгүй дагалднам.

*авйактад вйактайах сарвах
прабхаванти ахар – агаме
ратри – агаме пралийанте
ратраивавйакта – самджнаке*

“Брахмын өдөр эхлэхүйд үй олон амьд бодгалиуд орчлонд мэндлэх ба Брахмын шөнө болмогц тэд бүгдээрээ устмуй” (Бхагавад-гита, -8.18). Брахмын нэг өдөр өнгөрөхөд бүхий л доод эрэмбийн гаригсын систем усаар хучигдах ба Түүн дээр орших амьтас нь устаж үгүй болмуй. Энэхүү усан галвын дараагаар Брахмын шөнө дуусч Брахмын өглөө болоход бүтээл дахин шинээр эхэлдэг ба дээрхи бүхий л амьд бодгалиуд орчлонд дахин мэндэлдэг. Тэгэхлээр, материйн ертөнцийн ээлжлэн давтагддаг бүтээл хийгээд усталт нь түүний ялгарах шинж тэмдэг юм.

*бхута-грамах са эвайам
бхутва бхутва пралийате
ратри - агаме`ваших партха
прабхаватй ахар – агаме*

“Өдөр болмогц дахин дахин үй олон амьд бодгалиуд орчлонд мэндлэх ба дахин шөнө болмогц ай Партха минь ээ, тэр хөөрхийсүүд дахиад л илрээгүй төлөвт шингэмүй” (Бхагавад-гита, -8.19). Усан галав нь нэг ч амьд бодгальд таалагдахгүй байж болох ч бүхий л гариг эрхэс усанд живэхэд тэр гаригс дээрх амьтас усан доор, Брахмын шөнийн туршид оршин байх болдог. Гэвч өдөр болмогц энэ их ус аажмаар алга болмуй.

парас тасмат ту бхаво`нийо

*вйакто вйактат санатанах
йах са сарвешу бхутешу
нашйатсу на винашйати*

“Тэсэн ч энэхүү илэрч тодорсон хийгээд илэрч тодроогүй материйн хувьд трансцендент болоод мөнх өөр байгаль оршин буй. Энэхүү дээд байгаль хэзээ ч устаж мөхдөггүй бөгөөд материйн ертөнцөд бүх зүйл устаж үгүй болсон ч тэрээр өөрчлөгдөлгүй хэвээр баймуй” (Бхагавад-гита, -8.20). Бид материаллаг орчлонгийн хэмжээ хязгаарыг тодорхойлчихож чадахгүй ч Ведүүдээс бид, бүхий л бүтээл нь сая, сая орчлонгууд хийгээд энэхүү орчлонгийн гадна талд орших сүнсний ертөнц зэргээс тогтдог болохыг олж мэдэж болно. Тэнд орших бүх гариг эрхэс нь мөнх ба мөн тэдгээр дээр орших бүхий л амьд бодгалиуд нь мөнх юм. Энэ шүлэг дэхь *бхавах* хэмээх үг нь “байгаль” гэсэн утгатай ба энд өөр байгалийн тухай өгүүлэгдэж байна. Энэ ертөнцөд мөн л хоёр янзын байгаль оршин байдгийг бид мэднэ. Амьд бодгаль – энэ бол сүнс. Тэрээр материаллаг бие махбодийн дотор оршин байсан цагт бие махбодь хөдөлгөөнд ордог ба харин амьд бодгаль буюу сүнсний оч нь биеэс гарч одмогц бие махбодь хөдөлгөөнгүй болдог. Сүнсний байгалийг Кришнагийн дээд байгаль гэдэг ба харин материаллаг байгалийг доод байгаль гэдэг. Материйн ертөнцийн гадна талд бүрэн дүүрэн сүнсэрхэг дээд ертөнц оршин байдаг. Энэхүү баримт нотолгоог мэдэмхийрэн цэцэрхэх аргаар тогтоох боломжгүй. Телескопоор бид сая, сая оддыг харж болох ч тэдгээрт хүрч чадахгүй. Бид өөрсдийн бололцоо чадавхаа ухамсарлах ёстой. Хэрэв мэдэмхийрэн цэцэрхэх аргаар материаллаг орчлонг ч танин мэдэж чадахгүй бол түүний тусламжтайгаар хэрхэн яаж Бурханыг болоод Бурханы гариг орныг танин мэдэж чадах билээ. Турших аргаар үүнийг тогтоох боломжгүй. Бурханыг ойлгохын тулд бид “Бхагавад-гита”-г сонсох ёстой. Бид цэцэрхсэн эрдэм мэдлэг дээр үндэслэн бидний эцэг хэн болохыг мэдэж чадахгүй. Үүний тулд өөрийн ээжийгээ сонсох хэрэгтэй ба түүний үгийг итгэн хүлээж авах хэрэгтэй. Хэрэв бид түүнд үл итгэвэл юу ч мэдэж авч чадахгүй. Учир нь бидний эцэг хэн болохыг хэлж өгөх өөр арга зам үгүй. Үүнтэй адил, хэрэв бид Кришнагийн ухамсрын аргачлалыг зүгээр л даган мөрдөж байвал Кришна болоод Түүний өлгий нутгийн талаар бүгдийг мэдэж чадна.

Парас ту бхавах гэдэг нь “дээд байгаль” гэсэн утгатай ба харин *вйактах* гэдэг нь илэрч тодорсон төлөвт бидний харж буй зүйлсийг хэлдэг. Бид материаллаг орчлон нь дэлхий, нар, сар, од, эрхэс хэлбэрээр илэрч байгааг харж чадна. Харин энэхүү илэрч тодорсон орчлонгийн гадна талд өөр, мөнхийн ертөнц *авйактат санатанах* оршин байдаг. Материаллаг байгаль нь эхлэлтэй хийгээд төгсгөлтэй ч сүнсний байгаль нь *санатанах* буюу мөнх юм. Тэрээр эхлэл ч үгүй, төгсгөл ч үгүй. Ийм байж болно гэж үү дээ? Тэнгэрт үүл хөвж байвал тэрээр тэнгэрийн асар уудам хэсгийг халхалж байгаа мэт санагдаж болох ч үнэндээ бол энэ үүл нь ердөө тэнгэрийн өчүүхэн жижиг хэгийг халхалсан өчүүхэн жижиг элсэн ширхэг мэт юм. Үүл тэнгэрийг хэдэн зуун миль талбай хэмжээтэйгээр бүрхэхэд бидэнд үүл бүхий л тэнгэрийг бүрхсэн мэт санагддаг даа. Харин үүний шалтгаан нь бид л өчүүхэн жижигт байгаа юм. Үүн шиг энэ бүх материаллаг орчлон нь зах хязгааргүй сүнсний тэнгэр дэхь өчүүхэн жижиг үүлтэй адил. Тэрээр *махат-тамтва* буюу материар хучигдсан байдаг. Үүл нь үүсэн бий болоод устаж үгүй болдог шиг энэхүү материаллаг байгаль нь эхлэл хийгээд төгсгөлтэй. Үүл сарнин замхарч, тэнгэр цэлмэхэд бид бүх зүйлийг ямар л байх ёстой яг тэр төрхөөр нь олж хардаг. Бие махбодь нь мөн л бурханлаг сүнснийг хучсан үүлтэй адил. Бие махбодь нь тодорхой хугацааны туршид оршин байж, үр удмаа үлдээгээд, дараа нь хөгширч, эцэст нь нүд анидаг. Бидний нүдэнд үзэгдэх ямар ч материаллаг объект материаллаг байгальд угаас байх зургаан төрлийн хувирал өөрчлөлтийг дамжин өнгөрдөг: тэр үүсэн бий болдог, өсч бойждог, тодорхой хугацаанд оршин байдаг, үр удмаа үлдээдэг, өтлөж хөгширдөг, эцэст нь устаж үгүй

болдог. Энэхүү үүлийг санагдуулам, өөрчлөгдөмтгий байгалиас гадна өөр, мөнхийн сүнсний байгаль оршин буйн тухай Кришна айлджээ. Материаллаг байгаль устаж үгүй болоход *авйакта санатанах нь* урьд өмнөх шигээ хэвийн оршсоор байдаг.

Ведийн бичээсүүдэд материйн болоод сүнсний тэнгэрийн тухай олон олон нотолгоонууд байдаг. “Шримад-Бхагаватам”-ын 2-р дуулалд сүнсний тэнгэр хийгээд түүний оршин суугчдын тухай өгүүлэмж байддаг. Түүнд, сүнсний ертөнцөд сүнсний нисэх онгоцууд байдаг ба ангжирсан амьд бодгалиуд энэхүү аянга цахилгааны хурдаар дүүлэн нисдэг хөлөг онгоцоор хаа сайгүй аялдаг тухай өгүүлсэн байдаг. Ерөөсөө бидний энд харж буй юм болгон тэнд бий. Энэ материйн ертөнц дэхь бүх юмс сүнсний ертөнцөд орших зүйлсийн хуулбар дууримал хийгээд материйн ертөнц нь бидний кинонд үздэгтэй адил бодит юмсын хуулбар дүрс юм. “Шримад-Бхагаватам”-д зөвхөн материаллаг элементүүдийн холимог болсон энэ материйн ертөнц нь дэлгүүрийн цонхон дээрх, амьд эмэгтэй хүнийг дууриалган хийсэн хиймэл эмэгтэй хүн шиг үнэн бодит ертөнцийг дууриалган бүтээсэн тухай тайлбарласан байдаг. Эрүүл ухаантай, жирийн хүн бүрд хиймэл хүн гэдэг нь дууриамал зүйл гэдэг нь тодорхой. Шридхара Свами, материйн ертөнц нь сүнсний ертөнцийн хуулбар ба сүнсний ертөнц нь бодит оршдог тул материйн ертөнц бодит мэт санагддаг хэмээн өгүүлжээ. “Бодитой” хэмээх үгийг ямар утгын хүрээнд авч үзэж буйг тайлбарлах нь зүйтэй болвуу. Бодитой гэдэг нь устаж үгүй болохгүй хэмээсэн утгатай. Өөрөөр хэлбэл мөнхөд орших зүйл нь бодит юм.

*насато видйате бхаве
набхаво видйате сатах
убхайор апи дрито `нтас
тв ананйос таттва – даршибхих*

“Үнэнийг толидогч хүмүүн, үл оршигч нь цаг зуурын ба оршигч нь өөрчлөгдөшгүй хэмээх дүгнэлтэнд хүрмүй. Тэд, эдгээрийн аль алиных нь мөн чанарыг судалснаар энэ дүгнэлтэнд хүрдэг бөлгөө” (Бхагавад – гита,-2.16).

Жинхэнэ цэнгэл – энэ бол Кришна бөгөөд харин түр зуурын материаллаг цэнгэл нь хуурмаг юм. Хэн юмсыг байгаа төрхөөр харнав, тэрээр үнэн хэрэгтээ хуурмаг цэнгэлээс зайлсхийж буй хэрэг. Хүний амьдралын жинхэнэ зорилго нь сүнсний тэнгэрт хүрэх явдал ч гэлээ “Шримад - Бхагаватам”-д өгүүлснээр, ихэнхи хүмүүс энэ тухай мэддэггүй. Хүний амьдралын утга учир нь, бодит юм гэж юу болох, бодит ертөнцөд хүрч очих тухай ойлгоход оршино. Бүхий л ведийн бичээсүүд биднийг түнэр харанхуйгаас ангижран гарахыг уриалан дуудаж байна. Материаллаг ертөнц нь харанхуйн мөн чанартай бөгөөд сүнсний ертөнц нь гэрлээр бялхмал юм. Тэрхүү ертөнцийг гал ч, цахилгаан ч гэрэлтүүлэх шаардлагагүй байдаг. Кришна энэ тухай “Бхагавад - гита”-ийн 15-р бүлэгт (15.6):

*на тад бхасайате сурйо
на шашанко на паваках
йад гатва на нивартанте
тад дхама парамам мама*

“Миний гаригийг нар, сар хийгээд өөр ямар нэг гэрлийн эх үүсвэр гэрэлтүүлдэггүй билээ. Хэн түүнд хүрнэв тэрээр хэзээ ч энэ материйн ертөнцөд буцаж ирэхгүй” хэмээжээ.

Сүнсний ертөнцийг илрээгүй гэж нэрлэдгийн учир нь түүнийг материаллаг мэдрэхүйнүүдээр хүртэн мэдрэх аргагүйд оршино.

авйакто `кшара ити уктас

*там ахух парамам гатим
йам прайа на нивартанте
тад дхама парамам мама*

“Энэхүү дээд гариг орныг илэрч тодроогүй хийгээд цаг зуурын бус хэмээдэг ба түүнд хүрэх нь дээд зорилго байдаг. Амьд бодгаль түүн дээр морилон очвол тэрээр буцан нааш ирэхгүй бүлгээ. Энэ бол Миний орших орон юмаа” (Бхагавад-гита, - 8.21). Энэ шүлгэнд маш урт удаан аяллын тухай дурьджээ. Бид сансарт гарч бүх материаллаг орчлонг туулан нисээд түүний бүрхүүлийг нэвт гарч сүнсний ертөнцөд хүрэх хэрэгтэй. *Парамам гатим*: энэ нь хүний хийж чадах хамгийн том аялал юм. Энд, задгай сансарт гарч хэдэн мянган миль нисээд буцаж ирэх тухай яригдаагүй байна. Тиймэрхүү аялалд баатарлаг гэх юм юу ч үгүй юм. Бид бүхүй л материаллаг орчлонг туулан нисэх хэрэгтэй. Үүнийг зөвхөн Кришнагийн ухамсрын тусламжтайгаар гүйцэтгэж болох ба харин сансрын хөлөг үүнд тус болохгүй. Хэн байнга Кришнагийн ухамсарт оршин байж үхэх мөчдөө Кришнаг дурсан боднов тэрээр шууд сүнсний ертөнц өөд халин одно. Хэрэв бид эрдэм мэдлэг, цэнгэл жаргалаар дүүрэн байх тэр газарт мөнхөд амьдрахаар, тийшээ очихоор жаахан ч атугай хүсвэл шууд одоо л *сач-чид-ананда* бие махбодио хэлбэржүүлж эхлэх ёстой. Кришнагийн бие нь *сач-чид-ананда* (*шиварах парамах кришнах сач-чид-анада виграхх*) гэж ярьдаг. Бид Түүнтэй адил эрдэм мэдлэг, аз жаргалаар дүүрэн мөнхийн бие махбодитой ч тэр нь маш өчүүхний зэрэгцээ материаллаг бүрхүүлээр хучигдсан байдаг. Хэрэв бид ямар нэг аргаар энэхүү хуурмаг өмсгөлөө тайлан хаявал бид сүнсний хаант улсад хүрмүй. Түүнд хүрснээр, бид энэхүү ертөнц рүү буцаж ирэх шаардлагагүй болно(*йам прайа на нивартанте*).

Тэгэхээр хүн бүр Кришнагийн дээд гариг оронд (*дхама парамам*) морилон очихоор чармайх хэрэгтэй. Биднийг Өөр лүүгээ дуудахын тулд Кришна Өөрөө энд залардаг. Мөн түүнчлэн энэ зам мөрд хүргэх ариун судар бичгүүдийг үлдээн болгоодгийн зэрэгцээ Өөрийн жинхэнэ элч төлөөлөгчдөө илгээдэг. Харин бид зөвхөн амьд бодгальд ховорхон олддог амьдралын хүмүүний хэлбэрээ л ашиглах нь үлдэж байна. Энэ дээд гариг эрхэст хүрснээр хүмүүн хатуужил тэвчил хийх, бясалгалын йогоор хичээллэх шаардлагагүй болох ба харин тэр гаригт хүрч үл чадвал түүний бүхий л тэвчил, хатуужил ердөө дэмий цаг үрсэн хэрэг болох билээ. Зөвхөн хүмүүний амьдралын хэлбэрт л ийм боломж олддог. Ийм учраас засаг төр, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн үүрэг нь амьдралын хүмүүний хэлбэрийг олж төрсөн тэр л амьтсыг энэ төгс төгөлдөрт хүргэхийн тулд сургаж хүмүүжүүлэхэд оршино. Хэрэв хүн ердөө идэж, унтаж, өсч үржиж, муур, нохой мэт нэг нэгэнтэйгээ хэмлэлдэн зулгаалдаж байвал түүнийг соёл иргэншилт хэмээн тооцох аргагүй. Бид энэхүү эрдэм мэдлэгийг эзэмшин, бидний бодол санаа үргэлж Кришна дээр төвлөрөн байснаар Кришнагийн ухамсрын тэрхүү түвшинд хүрэхийн тулд хүний амьдралаа зөв зүйтэй ашиглах ёстой. Тэгснээр бид үхлийн мөчид шууд сүнсний ертөнцөд морилон очих болно.

*пурушах са парах партха
бхактия лабхйас тв анайасйа
йасйантах – стхани бхутани
йена сарвам идам татам*

“Бүхний дээр орших Дээд Бурханы Бодгальд зөвхөн цэвэр чин бишрэлийн тусламжтайгаар л хүрэлцэн очиж болмуй. Өөрийн орондоо залран байхын зэрэгцээ Тэрээр хаа сайгүй зорчдог ба бүх зүйл Түүнд оршмуй” (Бхагавад-гита, -8.22).

Хэрэв бид чингэхийг хүсвэл энэхүү дээд гариг орноо хүрч болох юм. Энэ шүлгэнд өгүүлснээр үүний тулд зөвхөн ганц л аргачлал *бхакти* байдаг тухай өгүүлжээ. *Бхактия* гэдэг нь Дээд Бурханд захирагдахуй чин бишрэл гэсэн утгатай. *Бхактия* хэмээх үг нь *бхадж* буюу “үйлчлэх” гэсэн үгнээс гаралтай. “Нарада-панчаратра”-д *бхакти* – г “хуурмаг өөрийгөө адилтгахаас ангид” хэмээн тодорхойлон тайлбарлажээ. *Бхакти* – гаар цэвэр бурханлаг сүнснийг тодорхойлдог ч энэ нь үнэн хэрэгтээ бие махбодид хамаардаг ба түүнтэй хамт байнга өөрчлөгдөж байдаг гадаад тэмдэглэгээнээс эгнэгт ангижрахаар хатуу шийдсэн тэр хүмүүн л түүнийг олж авдаг. *Бхакти* нь материтай ямар ч холбоо хамааралгүй өөрийн цэвэр сүнсний мөн чанараа ойлгон ухамсарлах явдал юм. Мөн чанартаа бол бид сүнсний гадаад бүрхүүл болох бие махбодь биш хийгээд үнэн хэрэгтээ Кришнагийн зарц албатууд, *даса* нар юм. *Бхакта* нар гэж өөрийн мөн чанар буюу Кришнад үйлчлэн зүтгэхээ ойлгосон хүмүүнийг нэрлэдэг. *Хришекена хрикеша – севанам*: өөрийгөө адилтгах хуурмаг төсөөллөөс ангижирснаар бид өөрсдийн мэдрэхүйгээ мэдрэхүйн эзэн Хришекеша буюу Кришнад үйлчлэн зүтгэхэд ашиглаж чадна.

Рупа Госвамигийн цохон тэмдэглэснээр Кришнад үйлчлэх бидний зүтгэл нь эерэг байх ёстой юм. Бид Бурханд үйлчлэн зүтгэснээрээ хариуд нь ямар нэг материаллаг шагнал урамшил горилдог нь үнэн. Үнэндээ бол материаллаг баялаг хүсэн Бурханд мөргөх нь Түүнд үл мөргөгч нараас хавьгүй илүү ч эцсийн эцэст бид тэрхүү материаллаг ашиг хонжоо хүсэх хүсэл сонирхлоосоо ангижрах ёстой. Бидний зорилго Кришнаг танин мэдэхэд орших ёстой. Кришна хязгааргүйн тул Түүнийг танин мэдэх боломжгүй ч бид Түүнийг тодорхой хэмжээгээр танин ойлгож болох юм. “Бхагавад-гита” нь чухамхүү Түүнийг танин ойлгоход зориулагдаж бидэнд заяасан билээ. Түүнд агуулагдах мэдлэгийг эзэмшиж бид Кришнагийн тааллыг ойлгох ёстой ба Түүнд эерэг байдлаар үйлчлэн зүтгэх буюу өөрөөр хэлбэл Тэр биднээс хүсэн болгоосон бүхнийг хийх ёстой. Кришнагийн ухамсрын сургаал, мэдлэг нь олон тооны ариун судар бичгүүдэд өгүүлсэн аугаа их мэдлэг ухаан бөгөөд *бхакти* – д хүрэхийн тулд тэднийг ашиглах ёстой бүлгээ.

Пурушах са парох: Сүнсний тэнгэрт Дээд Бурхан нь Дээд Бодгаль байдаг. Тэнд үй олон өөрөө гэрэлтэгч гаригс оршдог хийгээд тэр болгоныг Кришнагийн хувилгаан дүрүүд захирч байдаг. Эдгээр хувилгаан дүрүүд нь дөрвөн мутартай хэлбэр төрхтэй бөгөөд тэдний нэрэнд тоо үгүй. Тэд бүгдээрээ бие махбодитой бодгаль бөгөөд эдгээр *пурушагууд* /бодгалиуд/ -д зөвхөн бхактигийн тусламжтайгаар хүрч очиж болно. Үүнийг гүн ухааны бодол эргэцүүлэл юм уу, ургуулан төсөөлөх, бие махбодийн дасгал хөдөлгөөнөөр хийчих боломжгүй ба гагцхүү ямар ч ашиг хонжоо харсан бодол санаагүй чин бишрэл зүтгэлээр гүйцэтгэж болно.

Дээд Бодгаль буюу *пуруша* гэж юу юм бэ? *Йасьянтах-стхани бхутани йена сарвам идам татам* – бүхий л амьд бодгалиуд хийгээд бүхий л зүйлс Түүнд оршдог ба бүхэнд нэвтрэгч Тэрээр бүгдийн гадна оршдог. Яаж тэр вэ? Бурханыг нартай адилтгадаг: нар нэг газраа оршин байвч өөрийн туяа цацрагаар бүхэнд нэвтэрдэг. Бурхан Өөрийн *дхама парамам*-д үргэлж оршдог ба чингэвч Түүний эрч хүч хаа сайгүй тархдаг. Тэрбээр, нар өөрийн цацраг туяанаас ялгаатай бусын адил Өөрийн эрч хүчнээс үл ялгарнам бүлгээ. Кришна болоод Түүний эрч хүч нэг нэгнээсээ үл ялгарахын тул чин бишрэл зүтгэлийн тодорхой түвшинд хүрснээр бид Кришнаг хаа сайгүй харж чадна.

*преманджана-ччхурита-бхакти –вилочанена
сантах садаива хрдайешу вилокайанти*

“Би вээр Бурханы анхдагч Бодгаль Говинда танаа сөгдөн мөргөмү. Бурханыг хайрлах хайрын бальзам тосыг нүдэндээ түрхсэн чин бишрэлтэн нар нь Түүнийг өөрийн зүрхэндээ үргэлж толидон харах бөлгөө” (Брахма-самхита, -5.38). Бурханыг хайрлах хайраар бялхагч

хүмүүнд Тэрээр хэзээд нүднийх нь өмнө байж байдаг. Цэвэр чин бишрэлтэн нь Бурханыг шөнө зүүдэндээ харлаа гэх юм уу, огт Түүнийг хараагүй гэж ярьдаггүй. Үгүй. Хэнбээр Кришнаг ухамсарлан танинав, тэрээр Түүний оршин буйг үргэлж мэдэрч байдаг. Түүнийг олж харахын тулд бид зүгээр л хараа орох хэрэгтэй юм.

Болзолт материаллаг төлөвт бидний сүнсний мөн чанар материаллаг мэдрэхүйнүүдийн бүрхүүл дор хучигдсан байдаг. Ийм ч учраас бид сүнсний мөн чанартай зүйлсийг ойлгож чадахгүй юм. Гэвч харанхуй мунхагийн энэхүү төлвөөс Харе Кришна мантраг давтан уншихын тусламжтайгаар ангижирч болно. Чухан хэрхэн яаж тэр вэ? Унтаж буй хүнийг ямар нэг чимээ авиа гаргаснаар сэрээж болдог доо. Хүн хэдий ямар ч ухаан сэхээгүй төлөвт оршин буй ч /юу ч харахгүй, юу ч мэдрэхгүй, үнэр танарыг мэдэрдэггүй гэх мэт/ унтаж буй хүнийг зүгээр л ямар нэг авиагаар сэрээдэг болохоор сонсох мэдрэхүйн ямар их хөгжингүй болох нь тодорхой болж байна. Үүнтэй адил бурханлаг сүнс нь материтай хүрэлцсэний улмаас нойронд автаж буй бөгөөд түүнийг Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе мантраг давтан уншсанаас үүсэх трасцендент авиа чичирхийллээр “сэрээж” болно. Харе Кришна мантра нь Дээд Бурхан болоод Түүний эрчим хүчинд хандсан мөргөл дуудлага юм. Тэгэхлээр, Харе Кришна мантраг давтан дуудах үед бид: “Ай Бурханы эрч хүч минь ээ, ай Бурхан минь ээ, намайг хүлээн авч соёрхоо” хэмээж буй ажгуу. Бид Бурханаас ондоо юу ч гүйдаггүй. Хэрэв үргэлж бидний дэргэд талх байсаар байхад амин чухал хэрэгцээ болсон талх хайрлаач хэмээн Бурханаас гуйх нь ямар утга байнаа? Харе Кришна бол Түүнээс биднийг хүлээн авахыг гуйсан, Дээд Бурханд хандсан мөргөл юм. Чайтанья Махапрабху Бурхан Өөрөө:

*ай нанда-тануджа кинкарам
патитам мам вишаме бхавамбудхау
крпайа тава пада-панкаджа-
стхита-дхули-садришам вичинтайа*

“Ай Нанда Махараджын хүү минь ээ, Би Таны мөнхийн албат билээ. Гэвч би үхэх, төрөхийн далйд унаж орхижээ. Танаас гуйн мөргөө. Намайг энэ далайгаас татаж гаргаач. Би Таны бадамлянхуан өлмий дор орших өчүүхэн тоосонцор больё” (Шикшаштака, 5) хэмээн залбиран мөргөсөн байдаг. Далай дунд хаягдаж орхигдсон хүний хувьд хэн нэгэн хүн ирж түүнийг уснаас татаж гаргаасай гэсэн цор ганц хүсэлтэй л байдаг. Хэн нэг нь түүнийг уснаас хэдэн фут татаж гаргаж эхэлмэгц л тэрээр амсхийн тайвширдаг. Үүнтэй адил, зөвхөн Кришнагийн ухамсрын тусламжтайгаар л бид үхэх, төрөхийн далайгаас сугаран гарч чадах ба бид шууд л амар амгаланг мэдрэх болно.

Бид Дээд Бурханы трасцендент мөн чанар, Түүний нэр алдар, үйлийг ойлгож чадахгүй ч хэрэв бид Кришнагийн ухамарт батажвал Бурхан аажмаар бидэнд Өөрийгөө нээн өгнө. Бурханыг харахын тулд бидний зүгээс хүчин чармайлт гаргах нь хангалттай бус ч хэрэв бид өөрийгөө бэлдвэл Бурхан Өөрийгөө нээдэг. Тэр үед л бид Түүнийг харж чадна. Бурханыг бидний өмнө гарч ирэн бүжиглэхийг тушаах учиргүй. Түүнийг харахын тулд бид Кришна Өөрөө Өөрийгөө нээн соёрхох тийм байдлаар үйл хийх ёстой юм.

Кришна, Өөрөө Өөрийнхөө тухай “Бхагавад-гита”-д айлдсан буй. Түүний ярьсан, айлдсан болгон эргэлзээ үгүй хийгээд бид зүгээр л үнийг мэдрэх, үүнийг ойлгох хэрэгтэй. “Бхагавад-гита”-г шинж байдал, гарал үүсэл гэх зэргээс үл хамааран хүн бүр ойлгож чадна. Учир нь “Бхагавад-гита”-гийн түвшин нь Үнэмлэхүй түвшин юм. Кришнагийн нэрийг давтан дуудах жирийн энэ аргачлал нь л түүгээр хичээллэгч хүнд үүний бодгаль байдал, Бурханы мөн чанар, материйн болоод сүнсний орчлонгууд гэж юу болох, бидний болзолт байдлын шалтгаан юу болох, түүнээс хэрхэн ангижрах тухай бүгдийг нээн өгдөг.

Ийн бид аажмаар бүгдийг мэдэх болно. Үнэн хэрэгтээ итгэл болоод түүний дагалдаж ирэх танин ухамсарлахуйн холбоо бидэнд маш тодорхой байдаг. Бид үргэлж итгэлээр, ирээдүйд үүний үнэн болох нь батлагдана хэмээн найдаж байдаг. Жишээ нь, бид Энэтхэг явах билет худалдан авснаар бид энэ улс оронд хүрнэ гэдэгтээ итгэдэг. Үгүй бол энэ билетийн төлөө яах гэж мөнгө үрэх болж байна? Мөн бид анх уулзсан хүнд л мөнгөө өгчихдөггүй. Бид нэр хүндтэй, нислэгийн компани, тусгай нисэх шугам байдгийг мэддэг. Энэ бол бидний итгэх болсон шалтгаан Өдөр тутмын амьдралдаа ч гэсэн бид итгэлгүйгээр нэг ч алхдаггүй. Итгэл нь зайлшгүй байх ёстой хэдий ч нэр хүндтэй эх сурвалжуудын хүлээн зөвшөөрсөн зүйлд л итгэх хэрэгтэй. Сохроор итгэх нь маш зүй бус үйлдэл юм. Бид нийтээрээ хүлээн зөвшөөрдөг тэр л зүйлийг хүлээн авдаг. Энэтхэгт каст хийгээд анги давхаргаасаа үл хамааран бүгд л “Бхагавад-гита”-г аугаа бүтээл гэж үздэг. “Бхагавад-гита”-гийн бат ноттой нь эргэлзээ үгүй юм. Тэр ч атугай аугаа эрдэмтэн, профессор Альберт Эйнштейн “Бхагавад-гита”-г байнга уншдаг байжээ.

“Бхагавад-гита”-д сүнсний орчлон буюу Бурханы хаант улсын тухай өгүүлсэн байдаг ба бид үүнийг итгэн хүлээн авах ёстой. Хэзээ ч өвдөхгүй, өтлөхгүй, төрөхгүй, үхэхгүй тийм газар луу яв гэвэл бид баярлахгүй гэж үү? Тийм газрын тухай сонсмогц л бид гарцаагүй тийшээ очихын тулд бүх хүч чадлаа дайчлах болноо доо. Хэн ч өтлөхийг хүсдэггүй, хэн ч өвдөхийг хүсдэггүй. Гэвч эдгээр зовлон байхгүй тийм газрыг ол доо. Энэ бол бидний хамгийн хүсүүштэй зүйл мөн. Бид яагаад үүнийг хүсээд байгаа юм бэ? Яагаад гэвэл энэ нь зуун хувь зүй ёсны асуудал. Бид мөнх, аз жаргал, эрдэм мэдлэгээр дүүрэн гэлээ ч материаллаг бүрхүүлд хучигдсанаар өөрсдийн жинхэнэ мөн чанараа мартаж орхисон юм. Тиймээс “Бхагавад-гита” бидэнд өөрийн анхдагч төлөв байдалдаа буцаж очих боломж олгож байна.

Шанкаристууд болоод буддистууд ертөнцийн гадна тал нь хоосон хэмээн баталдаг ч “Бхагавад-гита”-д тийм сэтгэлээр унагах, урам хугалах нотолгоо үгүй юм. Хоосон чанарын гүн ухаан нь зөвхөн бурхангүй үзэлтнүүдэд үр өгөөжтэй. Бид - сүнсний амьтас хийгээд цэнгэн жаргахыг хүсдэг ч хэрэв бид ирээдүйд /дараа төрөлд/ биднийг хоосон орон зай хүлээж буй гэдэгт итгэвэл бидэнд материаллаг ертөнцөд, материаллаг амьдралаар цэнгэн жаргах хүсэл төрөх нь тодорхой. Энэ нь нэг талаас имперсоналистуудын хоосон чанарын гүн ухааны олон янзын байр суурийг хэлэлцэхэд хүргэдэг байхад нөгөө талаас илүү их материаллаг цэнгэл жаргал амтлах гэсэн хүсэлд хөтөлдөг. Иймэрхүү номчирхол нь ханамж өгч байгаа ч сүнсний аз жаргал авчирдаггүй.

*брахма-бхутах прасаннатма
на шочати на канкишати
самах сарвешу бхутешу
мад бхактим лабхате парам*

“Хэн бээр энэхүү трансцендент түвшинд хүрнэв, тэрээр шууд Дээд Бурханыг танин ухамсарламуй. Тэрээр хэзээ ч гашуудан гуниглахгүй хийгээд түүнд ямар ч хүсэл үгүй болмуй. Тэрээр бүхий л амьд бодгалиудад адил тэгш хандах бөлгөө. Энэхүү төлөвт л хүн цэвэр чин бишрэлийн түвшин өөд өгсөн дээшилдэг” (Бхагавад-гита, -18.54).

Чин бишрэл зүтгэлийн өндөртлөгт хүрсэн, Кришнад үйлчилснээр цэнгэл эдлэгч хүмүүний материаллаг цэнгэл жаргалд тэмүүлэх хүсэл сонирхол нь аяндаа үгүй болдог. Бхактид уусан автсан хүмүүнийг тэрээр, Кришнагаас, зөвхөн Түүнээс л ханамж авдаг байдлаар нь танин мэдэж болно.

Кришнаатай харьцахуй

Хэрэв хүн оронд нь илүү сайн зүйл олж авахаар бол хэрэгцээ муутай, чанаргүй эд баялагаас татгалзах нь хэцүү биш. Бид цэнгэн жаргахыг хүсдэг ч имперсонализм болоод хоосон чанарын гүн ухаан хэтэрхий ихээр тархсаны улмаас бид материаллаг цэнгэл жаргалд татагдахад хүрдэг. Бидний цэнгэлийн эх булаг нь Дээд Бодгаль (*пурушах са парах*) байх ёстой хийгээд Түүнтэй бид нүүр тулан уулзан учрах бололцоотой. Сүнсний ертөнцөд бид Бурхантай ярьж хөөрч, Түүнтэй тоглон наадаж, Түүнтэй хооллож ундаалж болох билээ. Энэ бүхэнд трансцендент хайраар үйлчлэн зүтгэхийн */бхактия/* тусламжтайгаар хүрч болно. Гэвч энэхүү зүтгэл нь бохир бузраас ангид байх ёстой бөгөөд өөрөөр хэлбэл бид хариуд нь ямар нэг шагнал, ашиг хонжоо горилолгүйгээр Бурханыг хайрлах ёстой юм. Түүнтэй нэгдэхийг санаархан Бурханыг хайрлах нь мөн л нэгэн төрлийн бохирдол юм.

Материйн ертөнцөөс сүнсний ертөнцийн ялгарах гол шинжүүдийн нэг нь сүнсний гаригсын захирагчдад өрсөлдөгч байдаггүй. Сүнсний бүх гаригуудыг Шри Кришнагийн бүрэн хувилгаан дүрүүд захиран залуурдаж байдаг. Дээд Бурхан хийгээд Түүний олон төрлийн илрэлүүд Ваикунтхийн бүхий л гариг дээр ноёлон байдаг. Дэлхий дээр ерөнхийлөгч юм уу ерөнхий сайдын суудлын төлөө байнгын тэмцэл өрнөж байдаг бол сүнсний ертөнцөд Дээд Бурханы Бодгалийн ноёлох байр суурийг бүгд үг дуугүй хүлээн зөвшөөрч байдаг. Хэн бээр Бурханыг үл хүлээн зөвшөөрч Түүнтэй тэмцэлдэхийг хүснэв, тэрээр яг л шорон гяндан мэт энэ материаллаг ертөнц рүү илгээгддэг. Дэлхийн аль ч хотод шорон гяндан бий хийгээд шоронгийн эзлэх газар нутгийн хэмжээ нь хотын бүхий л газар нутгийн өчүүхэн бага хэсгийг эзэлдэг. Үүн шиг материаллаг орчлон нь болзолт сүнснүүдийн шорон бөгөөд сүнсний тэнгэрийн өчүүхэн бага хэсгийг эзэлдэг. Гэвч тэрээр материйн ертөнцөд, шорон гяндан хотын захад оршдог шиг сүнсний ертөнцийн зах хязгаарт оршдог.

Сүнсний тэнгэрт орших Ваикунтхийн оршин суугчид нь бүгд ангижирсан сүнснүүд байдаг. “Шримад-Бхагаватам”-д өгүүлснээр, тэд яг Бурхан мэт бие төрхтэй байдаг аж. Нэг гариг дээр нь Бурхан Өөрөө хоёр мутарт хэлбэр төрхөөрөө илэрдэг байхад нөгөө гариг дээр Тэрээр дөрвөн мутарт хэлбэр төрхөөр илэрдэг. Тэдгээр гаригийн оршин суугчид нь мөн хоёр болон дөрвөн гартай бөгөөд тэднийг Дээд Бурханы Бодгалиас ялган таних аргагүй гэлцдэг. Сүнсний ертөнцөд хүрснээр олж авч болох таван янзын ангижирлын хэлбэр байдаг. Амьд бодгаль нь Дээд Бурханы бодгаль бус ахуй буюу Брахмантай нэгдвэл ийм төрлийн ангижирлыг *сайуджйа-мукти* гэдэг. Ангижирлын хоёр дахь хэлбэрийг *сарунйа –мукти* гэдэг. Түүнд хүрснээр амьд бодгаль нь Бурхантай яг адилхан биеийг олж авдаг. Гуравдахь нь *салокйа-мукти*. Энэ нь амьд бодгаль Бурхантай нэг гариг дээр амьдрах боломжтой болохыг хэлдэг. Харин *сарити-мукти*-д хүрснээр амьд бодгаль нь Дээд Бурханы эзэмшдэг шиг хэмжээний эд баялагтай болдог. Ангижирлын дараагийн хэлбэр нь Кришнага хаа ямагт дагалдан явах Түүний найз Арджунатай адил Түүний тойрон хүрээлэгчдийн нэг болж Бурхантай үргэлж хамтдаа байх боломжийг олгодог. Эдгээр таван хэлбэрийн ангижирлын алинд нь ч хүрч болох боловч чин бишрэлтэн - ваишнавүүд нь бодгаль бус хэлбэртэй нэгдэх буюу *сайуджйа-мукти* ангижирлыг үгүйсгэн татгалздаг. Ваишнав нь, Бурханд, Түүний үнэн дүр төрхөнд мөргөхийг болон Түүнд үйлчлэн зүтгэхийн тулд өөрийн тусгаар байдлаа хадгалан үлдэхийг хүсдэг байхад харин майвадийн сургуулийн имперсоналист-гүн ухаантнууд нь өөрийн тусгаар байдлаа орхиж Бүхний Дээдийн ахуйтай нэгдэхийг хүсдэг. Гэвч “Бхагавад-гита”-д Шри Кришна ч, багш шавийн хэлхээнд хамаарах гүн ухаантан-ваишнавүүд нь ч, бодгаль бус хэлбэртэй

нэгдэхийг зөвлөөгүй. Чаитанья Махапрабху Бурхан энэ тухай Өөрийн “Шикшаштака”(4)-д:

*на дханам на джанам на сундарим
кавитам ва джагад иша-камайе
мама джанмани джанманишваре
бхаватад бхактир ахаитуки твайи*

“Аяа Бүхнийг чадагч Бурхан минь ээ! Би ямар ч эд баялагтай болохыг хүсэхгүй. Надад үзэсгэлэнтэй сайхан эмэгтэй, үй олон шавь нар хэрэггүй. Би зөвхөн нэг л зүйлийн гуйн болгооё. Нэг амьдралаас нөгөө амьдралд Танд учир шалтгаангүйгээр чин бишрэлээр бишрэн зүтгэхийг хүсэн мөргөнөм”. Дахин дахин төрөх шаардлага шалтгаан нь ангижралд хүрээгүйг илтгэж байна. Ангижралд хүрснээр амьд бодгаль нь нэг бол сүнсний гаригст хүрэх буюу нэг бол Бүхний Дээдийн ахуйтай нэгддэг ч аль ч тохиолдолд нь тэрээр дахин материаллаг ертөнцөд төрөх шаардлагагүй болдог. Гэвч Чаитанья Махапрабхугийн хувьд Тэрээр ангижралд хүрэх эсэх нь ялгаагүй хийгээд Тэрээр ердөө зөвхөн ганцхан л зүйлийг хүсч байна. Тэр нь Кришнагийн ухамсарт үйл хийх боломжтой болох буюу Дээд Бурханд үйлчлэхийг хүссэн хүсэл юм. Чин бишрэлтэнд хаана оршин байх, юу болж төрөх нь (амьтан, хүн, сахиулсан тэнгэр гэх мэт) сэтгэлийг нь түгшээдэггүй. Харин тэрээр Бурханаас ганц зүйлийг гуйдаг нь тэрээр Түүнийг үргэлж дурсан санаж, Түүнд трансцендентаар үйлчлэн зүтгэх бөлгөө. Энэ бол цэвэр чин бишрэлийн шинж тэмдэг юм. Чин бишрэлтэн хаана ч байсан тэрээр материаллаг бие махбодитойгоор ч үргэлж сүнсний хаант улсад оршин байдаг. Гэвч тэрээр Бурханаас өөртөө зориулж, өөрийнхөө баяжих, дэвжих, тав тухтай амьдрахад хамаарах юу ч гуйдаггүй.

Кришна, хэн бээр Түүнд өөрийгөө даатгана, тэрбээр тун хялбараар Түүнд хүрч болох ч йогийн өөр аргаар хичээллэгч йогчид нь азгүйдлээс бүрэн дүүрэн ангид байдаггүй. Тэдэнд зориулж “Бхагавад-гита”-д (8.23) – ямар цаг мөчид бүдүүлэг бие махбодио орхиход тохиромжтой байдаг тухай заавар өгсөн байдаг.

*йатра кале тв анаврттим
аврттим чаива йогинох
прайата йанти там калам
вакшйами бхаратар шабха*

“Ай Бхаратын удмын шилдэг үр сад минь ээ, одоо Би чамд буцан харихын тулд буюу буцаж эргэн ирэхгүйн тулд хүмүүн энэ ертөнцөөс халин одож болох тохиромжтой цаг мөчүүдийн тухай өгүүлсүү”. Кришна энд, хэрэв хүн тохиромжтой цаг мөчид бие махбодио орхивол тэрээр ангижралд хүрэх бөгөөд хэзээ ч материаллаг ертөнцөд буцаж ирэхгүй тухай айлджээ Хэрэв тэрээр өөр цаг мөчид нас нөгчвөл буцаж ирэх ёстой болдог ба энд тохиолдлын хэмээх ухагдахуун явж байгаа боловч Кришнагийн ухамсарт үргэлж оршигч чин бишрэлтний хувьд тохиолдлын хэмээх энэ ухагдахууны тухай яриа ч байх аргагүй юм. Учир нь түүний Бурханд зүтгэх чин бишрэл нь Кришнагийн гариг орноо морилох баталгаа нь болдог.

*агнир джйотир ахах шуклах
шан-маса уттарайанам
татра прайата гаччхантти
брахма брахма-видо джананах*

“Дээд Брахманыг танин мэдсэн хүмүүн нь наран бөмбөрцгийн хойд хэсгээр аялан байх зургаан сар болон ургах сарын хоёр долоо хоногийн завсарт галын тэнгэр эрхшээн байх таатай, гэрэл гэгээтэй цаг мөчид энэ ертөнцөөс халин одмуй” (Бхагавад-гита, -8.24). Нар зургаан сар экватороос хойд туйлын чиглэлд, зургаан сар өмнөд туйлын чиглэлд оршдог. “Шримад-Бхагаватам”-д айлдсанаар, нар нь бусад гариг эрхэс шиг хөдөлдөг гэжээ. Хэрэв хүмүүн, нар дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст оршиж байх цаг мөчид нас нөгчвөл ангижралд хүрдэг байна.

*дхумо ратрис татха кринах
шан-маса дакишнайанам
татра чандрамасам джйотир
йоги прапйа нивартате*

*шукла-крише гати хи эте
джагатах шашивате мате
экайа йати анаврттим
анйайавартате пунах*

“Наран тэнгэрийн хойд хэсгээр аялж байх зургаан сарын буюу буурах сарын хоёр долоо хоногийн завсарт, харанхуй шөнө, манан татсан цаг мөчид энэ ертөнцөөс халин одогч йогчид нь Саран дээр морилон очих боловчиг дахин нааш буцаж ирэх болмуй. Ведэд өгүүлснээс үзэхэд, зарим хүмүүс нь гэрэлтэй цаг мөчид энэ ертөнцөөс халин оддог байхад зарим хэсэг нь харанхуйд оддог гэжээ. Хэрэв хүмүүн гэрэл гэгээтэй цаг мөчид нас нөгчвөл тэрээр буцан ирэхгүй ба харин харанхуй үед нас нөгчвөл буцаж ирэх болмуй” (Бхагавад-гита, -8.25-26).

Энэ бүгд тохиолдлын хэмээх ухагдахууны доор явагддаг. Хэзээ үхэхээ бид мэддэггүй. Бид ямар нэг азгүй тохиолдлоор хэзээ ч үхэж болох. Гэвч бхакти-йогийн хувьд Кришнагийн ухамсарт батжин тогтворжсон хүмүүн нь тохиолдлын хэмээх ухагдахуунаас ангид байдаг. Түүнийг аз болоод амжилт үргэлж дагалдаж байдаг.

*наите срти партха джанан
йоги мухйати кашчана
тасмат сарвешу калешу
йога-йукто бхаварджуна*

“Чин бишрэлтэн нар нь энэхүү хоёр замыг хоёуланг нь мэддэг юмаа, ай Арджуна минь ээ, гэвч энэ нь тэдний сэтгэлийг түшээдэггүй. Иймд чин бишрэл зүтгэлийнхээ үйлэнд үргэлж чанд хатуу байгтун” (Бхагавад-гита, 8.27).

Урьд өгүүлсэнчлэн хэрэв хүн үхэх мөчдөө Кришнагийн тухай бодвол тэрээр шууд Кришнагийн гариг оронд хүрдэг.

*анте-кале ча мам эва
смаран муктва калеварам
йах прапйати са мад-бхавам
йати настйа атра самшайах*

*абхйаса-йога-уйктена
четаса нанйа-гамина
парамам пурушам дивйам*

йати партханучинтайан

“Хэн бээр үхэх мөчдөө буюу бие махбодио орхих агшиндаа Миний тухай дурсан сананам бэ тэрбээр шууд Миний байгальд хүрмүй. Үүнд бүү эргэлзэгтүн. Дээд Бурханы Бодгалийн тухай үргэлж бодож, үргэлж намайг дурсан санадаг тэр хүмүүн нь өөр бусад юунд ч үл сатааран, ай Партха минь ээ, /Арджуна/ шууд Над руу ирмүй” (Бхагавад-гита, -8.5, 8.8). Тийм байдлаар Кришнаг бясалгах нь маш хүнд хэцүү мэт санагдаж болох ч энэ нь тийм биш. Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе маха-мантраг давтан дуудаж Кришнагийн ухамсарт дадлагажигч хүмүүнд энэ нь тийм ч хүнд биш юм. Кришна болоод Түүний нэр хоёр бие биенээсээ ялгаагүй ба Кришнагийн өлгий нутаг мөн ч түүнээс ялгаа үгүй. Авианы чичирхийллийн тусламжтайгаар бид Кришнаатай харьцаж чаддаг. Жишээ нь, гудамжинд явж байхдаа Харе Кришнаг уншсанаар Кришнаг бидэнтэй хамт явж буйг олж мэдэж болно. Бид дээш сар руу харвал тэрээр бидэнтэй хамт хөдөлж байгаа юм шиг харагддаг шүү дээ. Хэрэв Кришнагийн доод эрч хүч бидэнтэй хамт хөдөлж буй мэт санагдаж буй бол Түүний нэрийг давтан дуудахад Кришна Өөрөө бидэнтэй байж чадахгүй гэж үү? Тэрээр үргэлж бидэнтэй хамт байдаг ч Түүний тойрон хүрээлэгчдийн дунд орохын тулд бид тодорхой шинж чанарыг шингээсэн байх ёстой. Гэвч хэрэв бид Кришнагийн тухай бодолд үргэлж автвал Кришна бидэнтэй хамт гэдэгт итгэлтэй байж болно. Чаитанья Махапрабху Бурхан айлдахдаа:

*намнам акари бахурдха ниджа сарва шактис
татрарпита нийамитах смаране на калах
этадриши тава крпа бхагаван мамани
дурдаивам идришам ихаджани нанурагах*

“Ай Бурхан минь ээ, зөвхөн Таны ариун нэр л амьд бодгалиудад дээд сайн сайхныг авч ирж чадах бөлгөө. Ийм ч учраас Танд Кришна, Говинда гэх мэт зуу зуун, сая сая нэр бий билээ. Эдгээр бүх трансцендент нэрүүддээ Та Өөрийн бүхий л трансцендент эрч хүчийг шингээж өгсөн ба Таны нэрийг давтан уншихад тогтсон хатуу дэг жаяг байхгүй бүлгээ. Ай Бурхан минь ээ, Таны ариун нэрийг давтан дуудсанаар Тан руу хялбарханаар хүрч очих боломжийг сайн сэтгэлийн үүднээс Та бидэнд болгоосон ч Тэдгээр ариун нэрс Миний дур сэтгэлийг үл татах тул би тийм л өөдгүй үл бүтэх этгээд билээ”(Шикшаштака, 2).

Ариун нэрийг давтан дуудах нь Кришнаатай нүүр тулан уулзан учирсантай адил үр дүн авч ирдэг. Чаитанья Махапрабху Бурхан нь зүгээр нэг өөрийгөө ухамсарласан сүнс байгаагүй бөгөөд Түүнийг Кришнагийн Өөрийнх нь хувилгаан дүр гэж тооцдог. Тэрээр, энэхүү Калийн галавт өөрийгөө ухамсарлахуй аятай таатай нөхцөл үгүй ч энэ галвын хүмүүн нарт зориулагдсан *йуга-дхарма* буюу сүнсний өөрийгөө ухамсарлахуй аргачлал болгож, Кришна өгөөмрөөр бидэнд энэхүү *шабда*(авианд хувилсан Бурхан)-г хайрласан юм шүү хэмээн онцлон айлджээ. Энэхүү аргыг мөрдөхөд ямар нэг тусгай бэлтгэл хэрэггүй хийгээд тэр ч атугай санскрит хэл мэдэх ч шаардлагагүй. Санскрит хэл мэдэхгүй ч энэ мантраг хүн бүр уншин эхэлж болох тул Харе Кришнаг уншсанаас үүсэх авиа чичирхийллийн хүч чадлыг төсөөлөхөд ч бэрх.

*ведешу йаджнешу тапахсу чаива
данешу йат пунья-пхалам прадиштам
атйети тат сарвам идам видитва
йоги парам стханам упаити чадйам*

“Чин бишрэлийн зам мөр дээр гарсан хүн нь Ведийг судлах, өргөл тэвчил хийх, буян үйлдэх, гүн ухаан судлах, кармын үйл хийх гэх мэтийн үр шимээс хоцордоггүй. Тэрээр эдгээр хэлбэрийн үйлүүдийн авч ирэх бүхнийг хүртдэг бөгөөд эцэстээ дээдийн дээд гариг орноо хүрмүй ” (Бхагавад-гита, -8.28). Кришна энд, ведийн бичээсүүдийн бүхий л сургаал номлол нэг л зорилгыг агуулж байдаг буюу хүмүүнийг амьдралын дээд зорилгод хүрэхэд нь туслах буюу өөрөөр хэлбэл Бурхан зүг буцахад нь туслах зорилготой байдаг тухай айлджээ.

Дэлхий дээрх бүхий л ариун судар бичгүүд мөн нэг л зорилготой. Энэ бол бүх шашны зүтгэлтэн, *ачарйагуудын* үүрэг байсан юм. Жишээ нь, Баруунд энэхүү үүрэг даалгаврыг Иисус Христос гүйцэтгэсэн юм. Мөн Бурхан Будда, Мухаммед хоёр ч үүнийг хийж гүйцэтгэсэн. Тэдний хэн нь ч энэхүү материаллаг ертөнцийг өөрийн мөнхийн өмөг түшиг, нөмөр нөөлөг болгохыг хүмүүст зөвлөөгүй. Газар нутаг, цаг үе, нөхцөл байдал болон ариун судар бичгийн заалтаас хамаарч трансцендент бясалгагчдын сургаал нэг нэгнээсээ бага сага ялгарч болох ч үндсэн зарчим нь өөрчлөгдөлгүй үлддэг. Тэр нь, бид материйн ертөнцөд амьдрах ёсгүй ба харин сүнсний ертөнцөд л амьдрах ёстой тухай юм. Үүн дээр бүх трансценденталь бясалгагчдын үзэл бодол нийлдэг. Үхэх, төрөхийн нөгөө талд орших Кришнагийн ертөнцөд хүрснээр л бид өөрийн сүнсний хамгийн нандин хүслийг хангаж чадна хэмээн бүгд сурган номлодог юмаа.

Үгийн тайлбар

Аватар - үгчилбэл “буун заларсан тэр нэгэн”, сүнсний ертөнцөөс буун морилсон Дээд Бурханы хувилгаан.

Арати - Ёслол мөргөл. Энэ үеэр Бурханд хоол хүнс, зул, үнэртэн, цэцэг, дэвүүр зэргийг өргөмүй.

Арчана - Сүмд залсан Шүтээнд мөргөх зан үйл.

Асурууд - Чөтгөрүүд-атеистууд

Ачарйа - Өөрөөрөө үлгэрлэн дагуулагч номын багштан.

Ашрам – Сүнсний амьдралын дөрвөн үе шат.

Брахман - Бодгаль бус аспект дахь Туйлын Үнэн.

Брахман/брахмана/ - Цэвэр ариуны гунын нөлөөнд оршин буй хүмүүн; Ведийн нийгмийн дээд ангийн төлөөлөл.

Брахмачарйа - ёс журмыг сахигч шавийн амьдрал; сүнсний амьдралын эхний үе шат.

“Бхагавад-Гита” - Бурханы Өөрийн хайрласан нэн чухал бурханлаг сургаалууд.

Бхакт/бхакта/ - Бурханы чин бишрэлтэн.

Бхакти-йог – Онгод хөглөсөн чин бишрэл зүтгэлээр Дээд Бурхантай холбогдохуй

Ваикунтха - сүнсний ертөнц, “түгшүүр үгүй тэр газар”

Вайшнав - Бурхан /Вишнугийн/ Кришнагин чин бишрэлтэн.

Ваишйа – худалдаачид, фермерүүд; ведийн нийгмийн гуравдугаар анги давхарга.

Ванапрастха - Гэр бүлийн амьдралаас хөндийрөн татгалзсан тэр хүн; бурханлаг амьдралын гуравдугаар үе шат.

Ведүүд - анхлан Бурханы Өөрийнх нь айлдсан хамгийн анхдагч Бурханыг танихуй бичээсүүд.

Вишну Бурхан - материаллаг орчлонг тэтгэн баригч, тогтоон тэтгэгч Кришнагийн анхдагч экспанс.

Вйасадева - Кришангийн хувилгаан; Ведүүдийг бүтээхийн тул Двапара-югагийн төгсгөлөөр заларсан.

Вриндаван - Өөрийнхөө дур татам байдлыг бүрнээ илрүүлсэн Кришнагийн өлгий нутаг.

Голока - хамгийн дээд сүнсний гариг, Кришнагийн өлгий нутаг Вриндаван, Дварака, Матхур үүнд хамаармуй.

Гони - Кришнагийн найз-малчин бүсгүйчүүд, Түүний хамгийн дотны чин бишрэлтэнгүүд.

Грхастха - өөрийн амьдралаа ведийн ёс жаягаар цогцлоон бүтээсэн гэр бүлтэй хүмүүн; сүнсний амьдралын хоёрдугаар үе шат.

Гуру - номын багштан.

Джива – таттва - Бурханы өчүүхэн хэсэг, амьд бодгалиуд.

Дхарма - амьд бодгалиудын мөнхийн жам ёсны үүрэг алба, /өөрөөр хэлбэл Бурханд үйлчлэхүй/; шашны зарчим, дүрэм.

Йагйа - Өргөл тахилга; Бурхан Вишнугийн тааллыг хангахад чиглэсэн үйл.

Йогч - Алив нэгэн аргачлалаар Бурхантай холбогдохыг тэмүүлэгч бурханлаг үйлтэн

Кали-юга - /Калийн эрин/ одоогоос таван мянга орчим жилийн эхэлсэн, байнгын хэрүүл тэмцлээр дүүрэн өнөөгийн бидний амьдарч буй эрин. Энэ эрин нь халагдан ээлжлэх дөрвөн эриний хамгийн сүүлийнх нь ажгуу.

Караталууд -- киртан бясалгал явуулахад ашиглах цангууд.

Карма --- Үйл, түүний зорилго нь цэнгэл жаргал амой. Өөртөө үргэлж сайн болоод муу үр дагаврыг дагуулдаг.

Киртан -- Дээд Бурханы алдрыг магтан дуулах.

Кришналока --- **Голока**- г үз.

Кшатрийа --- Дайчид, удирдагчид; Ведийн нийгмийн хоёр дахь анги давхарга.

Майа -- (ма – биш, йа - энэ), хоосон хуурмаг; амьд бодгалийн Кришнаатай холбоо харьцаатайгаа үл санах мартагнал.

Майавади --- Бурхан нь трансцендент бие үгүй хэмээн батлах имперсоналист-гүн ухаантнууд.

Мантра --- Ухааныг хоосон хуурмагаас ангижруулагч авианы хэлбэлзэл.

Матхура -- Вриндаваны ойр орших Кришнагийн өлгий нутаг.Тэрээр Матхурт төрсөн бөгөөд Вриндаванд Өөрийн тоглоом наадгайгаа дуусгасны дараагаар мөн тийш буцан ирсэн.

Маха - мантра --- “ангижралын аугаа их дуулал”: Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама, Харе Харе.

Мрданга --- Бурханы ариун нэрийг хамтран дуулах үед хэрэглэх шавар бөмбөр.

Парампара --- Багш шавийн хэлхээ.

Прасад -- анхлан Бурханд өргөж ариуссан хоол хүнс.

Санкиртан -- Бурханы ариун нэрийг хамтран дуулах; энэхүү эриний хүмүүн нарт гойд тохирсон йогийн аргачлал.

Санниаса – Орчлонг огоорогчийн амьдрал; сүнсний амьдралын дөрөв дэхь үе шат.

Сач-чид-ананда-виграха -- мэдлэг болоод буянаар дүүрэн Бурханы мөнхийн трансцендент дүр.

Свами -- Өөрийн ухаан болоод мэдрэхүйнүүдээ захирагч; огоорлын сахил хүртсэн хүмүүнд олгох цол.

Тапасйа – Тэвчил; өндөр зорилгын төлөө ямар нэг зүйлээс сайн дураар татгалзах.

Тилак - Чин бишрэлтний биеийг ариусган шавраар үйлдэх онцгой тэмдэг.

Харе Кришна --- маха-мантра – г үз.

Шаструуд – Бурханыг танихуй бичээс.

Шраванам киртанам вишнох --- Бурхан Вишну болоод Түүний алдар гавъяаны талаар дуулах, сонсох, хүүрнэх -- чин бишрэлийн нэг хэлбэр.

Шудра -- ажилчин; ведийн нийгмийн дөрөвдүгээр анги давхарга.

Экадаши --- Сард хоёр удаа тохиох онцгой өдрүүд (ургах болоод шингэх сарын арван нэг дэхь өдөр), чин бишрэлтэн нар энэ өдрүүдэд мацаг барьж Кришнагийн тухай бодолд бүрнээ автмуй.

Йуга – Орчлонгийн амьдралын эрин. Дөрвөн йуга нь ээлжлэн давтагдах нэг циклийг бүрдүүлмүй.